



ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ



**МОНГОЛ УЛС
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ
ЦАХИМ ЭРҮҮЛ МЭНД ТӨСӨЛ**

ИРГЭНИЙ ЭРҮҮЛ МЭНДИЙН ЦАХИМ БҮРТГЭЛИЙН СИСТЕМ БАЙГУУЛАХ ТЕХНИКИЙН ШААРДЛАГА

Цахим эрүүл мэндийн удирдах хорооны
2019 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн
хурлаар хэлэлцэж дэмжсэн хувилбар

Улаанбаатар 2019 он

Агуулга

2. Үндсэн зарчим.....	6
3. Үндсэн ойлголт ба нэршлүүд	8
4. Үндсэн үйл ажиллагааны шаардлагууд	9
5. Өгөгдлийн бүтэц ба Өгөгдөл цуглуулах бодлого.....	10
6. Өгөгдлийн сангийн агуулга	11
7. Баримт бичиг хадгалах мэдээний сангийн агуулга	12
7.1. Гуравдагч талын Эмнэлгийн цахим бүртгэлийн баримт бичгүүд.....	12
7.2. Хавсаргасан тусгай файлууд	12
7.3. Эмнэлзүйн захиргааны баримт бичиг болон гэрчилгээ.....	13
8. Хандалт	13
2. Мэдээллийг нэгтгэх	14
3. Зохион байгуулалтын харилцан үйлчлэлцлийг хангах	15
4. Бүтцийн харилцан үйлчлэлцлийг хангах.....	15
5. Өгөгдөл цуглуулах бодлогыг хангах.....	16
6. Өгөгдлийн харилцан үйлчлэлцлийг хангах.....	17
7. Өгөгдлийн сангийн агуулга	17
8. Баримт бичгийн сан.....	17
8.1. Гуравдагч талын Эмнэлгийн цахим бүртгэл	17
8.2. Хавсаргасан тусгай файлууд	18
8.3. Эмнэлзүйн захиргааны баримт бичиг болон гэрчилгээнүүд	18
2. Ерөнхий шаардлага.....	29
3. Мэдээллийн эх сурвалж	30
3.1. Анхааруулга.....	30
3.2. Өнгөрсөн өвчлөлийн түүх	30
3.3. Одоогийн өвчлөлийн түүх.....	31
4.4. Эмийн мэдээлэл.....	32
4.5. Бусад мэдээлэлүүд	32
Шилжүүлгүүд.....	78
A.1.1. Анхан шатнаас лавлагаа шатлал (Secondary).....	78
A.1.2. Лавлагаа шатлалаас лавлагаа шатлал руу (Secondary to Secondary Care).....	79
A.1.3. Лавлагаа шатлалаас лавлагаа шатлал (Төрөлжсөн мэргэжлийн).....	80
A.1.4. Төрөлжсөн эмнэлэг хооронд.....	81
5. Үүрэг, хариуцлагатай холбоотой тодорхойлолтууд	103

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ИЭМЦБ	Иргэний эрүүл мэндийн цахим бүртгэл
ЭММСП	Эрүүл мэндийн мэдээлэл солилцооны платформ
ЭЦБ	Эмнэлгийн цахим бүртгэл
ГТ-ЭЦБ	Гуравдагч талын эмнэлгийн цахим бүртгэл
SSO	Single sign on
ҮОУА-9	Үйлдлийн олон улсын ангилал 9
ЭМД	Эрүүл мэндийн даатгал
CONTSYS	Тусламж үйлчилгээний тасралтгүй байдлын стандарт

БҮЛЭГ I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1. Энэхүү баримт бичиг нь Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 1 сарын 18-ны өдрийн 24 дүгээр тогтоолоор баталсан 2017-2026 онд хэрэгжүүлэх “Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого”-д тусгагдсан мэдээллийн технологи, мэдээллийн удирдлагын зорилтуудыг мэдээллийн технологийн сүүлийн үеийн арга хэрэгслүүдийг нэвтрүүлэх замаар хангах зорилготой.
2. Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогын энэхүү зорилгод хүрэхийн тулд олон улсын стандартуудыг өөрийн орны онцлогт уялдуулан нэвтрүүлэх, Үндэсний түвшинд эрүүл мэндийн мэдээлэл солилцох платформ байгуулах зайлшгүй шаардлагатай (хавсралт 1).
3. Үндэсний түвшинд эрүүл мэндийн мэдээлэл солилцох платформ байгуулахын тулд дараах зорилтуудыг хэрэгжүүлнэ. Үүнд:
 - 3.1. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд оролцож буй эрх бүхий бүх оролцогчдод Эмнэлзүйн шийдвэр гаргах үйл явцад дэмжлэг үзүүлэх үндэслэлтэй, стандартчилсан өгөгдөл цуглуулах бодлого, загвар бүхий ИЭМЦБ-ийг хэрэгжүүлэх;
 - 3.2. ИЭМЦБ ба гуравдагч талын мэдээллийн системүүдийн хооронд өгөгдөл, баримт бичгийн солилцоо хийх хэрэгслийг боловсруулж, хэрэгжүүлэх;
 - 3.3. Үйлчлүүлэгчийн болон эмнэлзүйн өгөгдлүүдийг тодорхойлж, ангилах чадвартай, харилцан үйлчлэлцэл бүхий Үндэсний лавлагаа мэдээллийн санг бүрдүүлэх;
 - 3.4. ИЭМЦБ-тэй уялдсан цахим жорын үйлчилгээг хөгжүүлж нэвтрүүлэх;
 - 3.5. Цахим шилжүүлгийн үйлчилгээг хөгжүүлж, нэвтрүүлэх;
4. ЭММСП-ын хэрэгжилтээс гарах үр дүнг дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:
 - 4.1. Өрхийн эмч нь янз бүрийн шатанд, өөр өөр эмнэлгийн мэргэжилтэн, түүний үзүүлсэн тусламж үйлчилгээ, тэдгээрийн үр дүн зэрэг өөрсдийн өвчтөний эмнэлзүйн зураглалын талаар үндсэн мэдээллийг бодит цаг хугацаанд харах боломж бүрдсэн байна.
 - 4.2. Өвчтөний хураангуй мэдээллийг боловсруулж, түүнийг харах, хандах боломжтой болно.
 - 4.3. Стандартын шаардлага хангасан эрх бүхий гуравдагч талын мэдээллийн систем нь Эмнэлгийн цахим бүртгэлээр дамжуулан үйлчлүүлэгчид үзүүлсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний мэдээллийг ИЭМЦБ-ийн систем рүү илгээдэг болсон байна.
 - 4.4. ИЭМЦБ-ийн стандартад нийцсэн эмнэлгийн цахим өгөгдлүүдийн болон
 - 4.5. ИЭМЦБ-тэй уялдсан цахим жорын үйлчилгээг хөгжүүлж нэвтрүүлсэн байна.

4.6. Цахим шилжүүлгийн үйлчилгээг хөгжүүлж, нэвтрүүлснээр иргэдэд чирэгдэлгүй, хүртээмжтэй, тасралтгүй эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

5 Энэ баримт бичигт эрүүл мэндийн мэдээлэл солилцооны платформын хүрээнд дараах систем, үйлчилгээний техникийн шаардлагыг тодорхойлов. Үүнд.

- Иргэний эрүүл мэндийн цахим бүртгэлийн систем
- Эмнэлгийн цахим бүртгэлийн системийн өгөгдлийн солилцоо
- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд оролцогч талуудын ялган таних
- Үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн хураангуй түүх
- Цахим шилжүүлэг
- Цахим жор

БҮЛЭГ II. ИРГЭНИЙ ЭРҮҮЛ МЭНДИЙН ЦАХИМ БҮРТГЭЛИЙН СИСТЕМИЙН ТЕХНИКИЙН ШААРДЛАГА

1. Зорилго

1.1. Энэхүү техникийн шаардлагын зорилго нь эрүүл мэндийн мэдээлэл солилцооны платформын үндсэн бүрэлдэхүүн хэсэг болох Иргэний эрүүл мэндийн цахим бүртгэлийн систем бий болгоход оршино. ИЭМЦБ нь Үндэсний түвшинд эрүүл мэндийн байгууллага хооронд харилцан үйлчлэлцэл бүхий мэдээлэл солилцох, хуваалцах, иргэн өөрийн авсан тусламж үйлчилгээг хянах боломжийг бүрдүүлэх ба дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

1.1.1. Олон улсын стандартуудыг нэвтрүүлэх

1.1.2. ИЭМЦБ-ийн үндсэн ойлголтууд, үзэл баримтлал, үйл ажиллагааг хэрэгжүүлэх, мөрдүүлэх, хөгжүүлэх

1.1.3. Өгөгдөл цуглуулах бодлогыг хэрэгжүүлэх, мөрдүүлэх, хөгжүүлэх

1.1.4. Өгөгдлийн агуулгад тавигдах шаардлага, техникийн тодорхойлолтуудыг хэрэгжүүлэх, мөрдүүлэх, хөгжүүлэх

2. Үндсэн зарчим

2.1. Энэхүү журмын 1 дэх заалт, Эрүүл мэндийн тухай хууль болон бусад дүрэм, журмын хүрээнд ИЭМЦБ-ийн систем нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээний цогц, тасралтгүй байдлын хангахад идэвхитэй дэмжлэг үзүүлэх зайлшгүй шаардлагатай олон улсын стандартуудыг нэвтрүүлнэ. Үүний тулд Монгол улсын ИЭМЦБ-ийн систем нь олон улсын “ISO13940-2015 Тусламж үйлчилгээний тасралтгүй байдлын үзэл баримтлалын тогтолцоо” (Цаашид CONTSYS гэх) стандартыг өөрийн орны онцлогт уялдуулан нэвтрүүлнэ. Ингэснээр эмнэлзүйн мэдээллийн тохирох нэршлийн ангилал болон өгөгдлийн утга зүйн (семантик) зохион байгуулалтыг нэвтрүүлнэ.

2.2. Монгол улсын ИЭМЦБ-ийн системд тусламж үйлчилгээний тасралтгүй байдал (CONTSYS) нэвтрүүлснээр боломжтой бүх мэдээллийн системээс бүрэн харилцан үйлчлэл бүхий эрүүл мэндийн болон эрүүл мэндийн тусламж үйлчилгээний мэдээллийг цуглуулж, дахин хуваарилах бөгөөд энэ нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээний цогц, тасралтгүй байдлыг хангах үйл ажиллагааны салшгүй нэг хэсэг болно.

2.3. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний эрхийн удирдлагыг стандартчилснаар эрүүл мэндийн өгөгдлийн зөв зохистой утга зүйн (семантик) зохион байгуулалт ба бүтэц, өвчтөн шилжүүлэх үйл ажиллагааны зохицуулалтыг бий болгож, улмаар тусламж үйлчилгээний тасралтгүй байдлыг хангахад дэмжлэг үзүүлнэ.

2.4. Бүх шатны эмнэлгийн цахим бүртгэлийн систем нь (Цаашид ЭЦБ гэх) энэхүү журам буюу тусламж үйлчилгээний тасралтгүй байдал (CONTSYS)-д нийцсэн байх ёстой.

2.5. ИЭМЦБ-ийн систем нь эмчийн ба иргэний портал гэсэн үндсэн хэсэгтэй байна.

- 2.6. Эмчийн портал нь ИЭМЦБ-ийн системийн өгөгдөл болон түүнд харгалзах мэдээлэлд хандаж ашиглах боломжийг олгоно. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэх эрх бүхий эмч, эмнэлгийн мэргэжилтэнгүүд нь зөвхөн зөвшөөрөгдсөн мэдээллийн хэсэгт хандах эрхтэй байна.
- 2.7. Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд нь үйлчлүүлэгчийн талаарх мэдээллийг эмчийн портал ашиглан оруулна. Үүнд:
- Эрх, сумын эрүүл мэндийн төвийн эмч нь иргэний болон өрхийн эрүүл мэнд, тусламж үйлчилгээний талаарх мэдээллийг батлагдсан бүртгэл, маягтын дагуу оруулна.
 - Хувийн үүдэн эмнэлгүүд нь тусламж үйлчилгээ үзүүлсэн мэдээллээ оруулна.
- 2.8. Дүрс оношилгооны зурган мэдээллийг харуулах DICOM хэрэгсэлтэй байна.
- 2.9. Үйлчлүүлэгчийн портал нь ИЭМЦБ-ийн системд иргэн өөрийн өгөгдөл болон түүнд харгалзах мэдээлэлд хандаж ашиглах боломжийг олгоно. Энэхүү порталд цахим гарын үсэг бүхий иргэн бүр хандах эрхтэй байна. Иргэн өөрийн мэдээлэлд эмч эмнэлгийн мэргэжилтэн хандах эрхийг нээх, хаах болон өөрийн эрхийг итгэмжлэгдсэн этгээдэд шилжүүлж болно.
- 2.10. ИЭМЦБ-ийн систем рүү мэдээлэл илгээх эмнэлгийн мэдээллийн системийг Гуравдагч талын эмнэлгийн цахим бүртгэлийн систем (ГТ-ЭЦБ) гэх бөгөөд дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
- 2.10.1. Энэхүү баримт бичигт хэрэглэсэн ойлголт, нэр томьёо, өгөгдлийн утга зүйн зохион байгуулалтанд нийцүүлэн Гуравдагч талын мэдээллийн системээс ИЭМЦБ-ийн систем рүү өвчний түүхийг илгээх, нэгтгэх механизмыг бий болгох;
- 2.10.2. Энэхүү баримт бичигт хэрэглэсэн ойлголт, нэр томьёо, өгөгдлийн семантик зохион байгуулалтанд нийцүүлэн ИЭМЦБ-ийн систем болон Гуравдагч талын мэдээллийн систем хоорондоо HL7 CDA/FHIR олон улсын стандартуудын дагуу эмнэлгийн цахим баримт бичгүүдийг солилцох; Тухайлбал, ИЭМЦБ-ийн системээс үүсгэх үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн хураангуй түүх, өвчтний цахим шилжүүлэг, цахим жорыг солилцох, Гуравдагч талын мэдээллийн системээс ирүүлсэн эмнэлгийн цахим баримт бичгүүдийн хүлээн авах, ИЭМЦБ-ийн өгөгдлийн болон үйл явцын стандартанд нийцүүлэн хувиргах зэрэг болно.
- 2.10.3. Гуравдагч талын мэдээллийн систем байхгүй хэрэглэгчид ИЭМЦБ-ийн системийн эмчийн портал ашиглан мэдээллээ оруулж болно.
- 2.11. Өгөгдөл цуглуулах бодлогод нийцсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд оролцогч талуудын ялган таних болон эмнэлзүйн өгөгдлийг ангилах, ялган таних зорилго бүхий Эрүүл Мэндийн Лавлагаа Мэдээллийн санг ИЭМЦБ-ын системд бий болгоно.
- 2.12. ИЭМЦБ систем нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тасралтгүй, цогц байдлын зарчмуудыг хангасан зөв зохистой өгөгдөл цуглуулах үйл ажиллагааг хэрэгжүүлснээр эрүүл мэндийн болон тусламж үйлчилгээний үйлчлүүлэгчид суурилсан, эмнэлзүйн хувьд уялдаа холбоо бүхий мэдээллийн бэлэн байдлыг бий болгоно.

- 2.13. ИЭМЦБ нь системийн хувьд Үндэсний Дата Төвийн төрийн нууцлал, хамгаалт бүхий сүлжээний бүсэд байршуулж бүх түвшинд мэдээллийн аюулгүй байдлын ISO 27000 (MNS 27000) багц стандартыг дагаж мөрдөнө.

3. Үндсэн ойлголт ба нэршлүүд

- 3.1. Олон улсын стандартын дагуу ИЭМЦБ-ийн систем нь өгөгдлийн утга зүйн (семантик) зохион байгуулалт бүхий **Тусламж үйлчилгээний эписод гэсэн үндсэн ойлголтыг** хэрэгжүүлнэ. Энэ нь анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын буюу Өрхийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний эписодыг бусад эрүүл мэндийн байгууллага болон лавлагаа шатлалд үүссэн Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний эписодтой нэгтгэнэ (хавсралт 2).
- 3.2. ИЭМЦБ-ийн системд үүсч бий болох Тусламж үйлчилгээний эписод нь үйлчлүүлэгчид суурилсан эмнэлзүйн мэдээлэл байх бөгөөд тухайн харгалзах онош бүхий *эрүүл мэндийн байдал, эрүүл мэндийн тулгамдсан асуудлууд болон эрүүл мэндийн тусламж үйлчилгээнүүд* зэргийг хамарсан байна.
- 3.3. ISO13940-2015 стандартад тодорхойлсноор **Эрүүл мэндийн байдал гэдэг нь** нэг ба түүнээс олон тусламж үйлчилгээ үзүүлэгчийн тодорхойлсон тухайн үйлчлүүлэгчийн эрүүл мэнд эсвэл эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авахтай холбоотой байдлыг хэлнэ.
- 3.4. *Эрүүл мэндийн байдал* нь үйлчлүүлэгчийн эрүүл мэнд, үйлчлүүлэгчид үзүүлсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбоотой маш өргөн хүрээний ойлголт учраас өвчтний талаарх өгөгдлийг нэгтгэх, хуваалцах боломжийг олгож, ерөнхий мэдээллээс илүү нарийн мэдээлэл рүү шилжих, улмаар тусламж үйлчилгээний өөр өөр түвшинг ИЭМЦБ-ийн мэдээний санд уялдуулж нэгтгэнэ. Өгөгдөл зохион байгуулах үндсэн ойлголтонд *эрүүл мэндийн байдал, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, эрүүл мэндийн тулгамдсан асуудлууд, үр дүн, өвчлөл, мэс засал, мэс ажилбарын хүсэлтүүд* хамаарна.
- 3.5. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний эписод нь үйлчлүүлэгчийн өгөгдлийн эмнэлзүйн уялдаа холбоог хангах зорилгоор *эрүүл мэндийн байдал болон эрүүл мэндийн тулгамдсан асуудал* гэсэн ойлголтыг хоёуланг хамарна. Энэ хоёр ойлголт нь өөр өөр байгууллага, шатлалд хандсан үйлчлүүлэгчийн эмнэлзүйн хувьсал өөрчлөлтийг харуулсан тусламж үйлчилгээний шалтгаанууд, эмнэлэгт хандсан талаарх мэдээллүүдийг цуглуулан нэгтгэхэд ашиглагдах бөгөөд эрүүл мэндийн байдал нь амбулаторийн тусламж ялангуяа анхан шатны тусламж үйлчилгээг илэрхийлэхэд, эрүүл мэндийн тулгамдсан асуудал нь эмнэлэгт хандах (энкаунтер), оношлогоо, мэс ажилбар хийлгэх хүсэлт, үр дүн, эмчилгээ болон бусад арга хэмжээний талаарх шалтгааныг харуулна.
- 3.6. Дээр дурдсан шаардлага болон ойлголтуудын дагуу ИЭМЦБ-ийн систем нь уялдаа холбоо бүхий эмнэлзүйн өгөгдөл цуглуулах, анхан шат, лавлагаа шатлалын түвшинд үүссэн Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний эписодуудын нэгдсэн бүтцийг бий болгох замаар эмнэлзүйн өгөгдөлөө хуваалцах боломжийг бүрдүүлнэ.

- 3.7. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний эписодын нэгдсэн бүтэц нь ИЭМЦБ-ийн системд байрших бөгөөд тусламж үйлчилгээний өөр өөр түвшин дэх тусламж үйлчилгээнүүдийг нэмэлтээр баримтжуулах замаар тусламж үйлчилгээний тасралтгүй байдлыг хангана.
- 3.8. Тусламж үйлчилгээний бүх эписодууд нь тусламж үйлчилгээний эрх, үүрэг олгох болон эмнэлзүйн захиргааны дүрмийн хүрээнд тодорхойлогдоно.
- 3.9. Дээрх шаардлагад нийцүүлэн Эрх, сумын эмч нь анхан шатны тусламж үйлчилгээний эписодуудыг нэгтгэх, дагах, удирдахаас гадна лавлагаа шатны тусламж үйлчилгээ авахаар тусламж үйлчилгээний эрх, үүргээ бусад тусламж үйлчилгээ үзүүлэгчдэд шилжүүлснээр лавлагаа болон бусад түвшинд үүссэн тусламж үйлчилгээний эписодуудыг нэгтгэх үүргийг хүлээнэ.
- 3.10. Тусламж үйлчилгээний тасралтгүй байдал (CONTSYS)-ийг дэмжихийн тулд ISO13940-2015 стандартын шаардлагатай ойлголт, нэршил, тодорхойлтуудыг өөрийн орны онцлогт тохируулан хэрэгжүүлнэ.
- 3.11. Тусламж үйлчилгээний тасралтгүй байдал (CONTSYS)-ыг хэрэгжүүлэхэд ИЭМЦБ болон ЭЦБ-ийн бүрэлдэхүүн элементүүдийн талаарх ойлголтыг авч үзэх шаардлагатай. Өөрөөр хэлбэл үйлчлүүлэгч эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгчид хандсан хандалт бүр өгөгдлийн загварын (data model) бүрэлдэхүүн хэсэг гэж үзнэ. Энэ ойлголтын хүрээнд тусламж үйлчилгээний эписод нь тодорхой цаг хугацааны туршид үүсэх бөгөөд эхлэл нь тухайн эрүүл мэндийн тулгамдсан асуудлаар эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгчид хандсан хамгийн анхны хандалт нь байх бөгөөд төгсгөл нь тухайн эрүүл мэндийн тулгамдсан асуудлаар тусламж үйлчилгээ үзүүлэгчдээс үзүүлсэн тусламж үйлчилгээнүүдийн хамгийн сүүлийн хандалт байна.

4. Үндсэн үйл ажиллагааны шаардлагууд

ИЭМЦБ болон Гуравдагч талуудын ЭЦБ-ийн систем нь журамд заасны дагуу дараах үндсэн үйл ажиллагааны шаардлагыг хангасан байна. Үүнд:

- 4.1. Дискрет ба стандартчлагдсан өгөгдөл (ISO13940), дискрет, бүтэцлэгдсэн, стандартчлагдсан баримт бичгүүд (HL7 CDA/FHIR), бүтэцлэгдээгүй, стандарчлагдаагүй эмнэлгийн баримт бичгүүд (ISO HL7 DIS 10781 EHRS FM/ISO 13606) стандартуудын шаардлагуудад нийцсэн байх
- 4.2. ИЭМЦБ-ийн систем нь үйлчлүүлэгчийн идэвхтэй болон идэвхгүй байгаа бүх эрүүл мэндийн байдлын дискрет өгөгдлийг цуглуулах, унших, зохион байгуулах боломжийг бүрдүүлэх
- 4.3. ИЭМЦБ-ийн систем нь тусламж үйлчилгээний эписодын үүссэн болон дууссан цаг хугацааны мэдээлэлд үндэслэн тусламж үйлчилгээний эписодыг удирдах боломжийг бүрдүүлэх
- 4.4. ИЭМЦБ-ийн систем нь тухайн эрүүл мэндийн байдалтай холбогдох эписодын /архаг, хурц/ үргэлжлэх хугацааг удирдах боломжийг бүрдүүлэх
- 4.5. ИЭМЦБ-ийн систем нь эрүүл мэндийн байдал, эписодын онош болон бусад ИЭМЦБ-ийн дурын өгөгдлөөр хүссэн хэлбэрээр хүснэгтэн болон график тайланг динамикаар үүсгэх, зохион байгуулах боломжтой байх,

шаардлагатай тохиолдолд (халдварт өвчин, сэтгэцийн эмгэг гэх мэт) эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгч болон үйлчлүүлэгчид төрөл бүрээр анхааруулга мэдээ өгдөг байх

- 4.6. ИЭМЦБ-ийн систем нь тусламж үйлчилгээний эпизодыг идэвхгүй болгох, идэвхижүүлэх боломжтой байх
- 4.7. ИЭМЦБ-ийн систем нь нэг болон түүнээс дээш эрүүл мэндийн байдалтай холбоотой үйл ажиллагаанууд, эрүүл мэндийн байгууллагад хандсан хандалтуудыг хооронд холбох боломжийг бүрдүүлэх
- 4.8. Энэ журамд заасны дагуу ИЭМЦБ-ийн систем нь тусламж үйлчилгээний өөр өөр шатлалд үүссэн эрүүл мэндийн байдлуудыг хооронд нь холбох боломжтой байх
- 4.9. ИЭМЦБ-ийн систем нь тусламж үйлчилгээний өөр өөр түвшинд үүссэн эрүүл мэндийн байдлуудыг дахин холбох боломжийг бүрдүүлсэн байх; тухайн асуудлыг шийдвэрлэхтэй холбоотойгоор түр мэдээний санг үүсгэн төлбөрийн нэхэмжлэлийг дахин тооцоолох гэх мэт тохиолдолд ашиглах,
- 4.10. Эрүүл мэндийн даатгалын сангаас иргэний эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийн мэдээллийг вэб сервисээр харуулах зэрэг болно.

5. Өгөгдлийн бүтэц ба Өгөгдөл цуглуулах бодлого

- 5.1. ИЭМЦБ-ийн систем харилцан үйлчлэлцэл бүхий мэдээлэл солилцох зорилтыг хангахын тулд дараах өгөгдөл цуглуулах бодлогыг баримтална.
 - a. ИЭМЦБ-ийн системийн үндсэн ойлголт, нэршил, стандартыг хэрэгжүүлэх гол механизм бол ИЭМЦБ-ийн Үндсэн өгөгдлийн мэдээний сан (Core Database) юм. Үндсэн өгөгдлийн мэдээний сан нь энэ журамд тодорхойлсон семантик зохион байгуулалт болон эмнэлзүйн өгөгдлүүдийн хүрээнд тодорхойлогдсон бүрэн цахимжсан эмнэлзүйн мэдээллүүдээр хангана(ISO13940:2015)
 - b. Түүнчлэн ИЭМЦБ нь эмнэлгийн цахим баримт бичиг (Electronic Medical Document, HL7 CDA/FHIR) хадгалах мэдээллийн хэсэг (Electronic Document Repository)-тэй байна.
 - c. ГТ-МС-ийн системээс ИЭМЦБ-ийн систем рүү шилжүүлсэн эсвэл эмчийн портал ашиглан ИЭМЦБ-д дотоодод үүсгэсэн Эмнэлгийн цахим бичиг баримтууд нь Цахим баримт бичиг хадгалах мэдээллийн хэсэгт хадгалагдана.
 - d. Бүх эмнэлгийн цахим баримт бичгүүд нь олон улсын HL7 CDA/FHIR стандартуудад нийцсэн байна.
 - e. Эмнэлгийн цахим баримт бичгүүд(HL7 CDA/FHIR) нь ИЭМЦБ-ийн системийн Үндсэн өгөгдлийн мэдээний санд цуглуулагдаж, хадгалагдаж, харилцан солилцох үед харгалзах тохиолдол бүртэй шууд, байнгын холбоосоор индексжүүлж, тухайн харгалзах мэдээллүүдтэй холбоо үүсгэнэ. Эмнэлзүйн, эмнэлзүйн-захиргааны болон тайлагнал, тухайлбал хэвтэн эмчлүүлсэн тухай тэмдэглэл, эмчийн үзлэгийн тэмдэглэл, цахим шилжүүлэг, жор, нарийн

мэргэжлийн эмнэлгээс гарагчийн хураангуй, болон бусад тайлагналтай холбоотой мэдээлэлүүд хамаарна.

- 5.2. Бүрэн цахимжсан гэдэг нь клиникийн мэдээллийн ангилал, ялган таних олон улсын стандартуудыг нэвтрүүлж, бүх өгөгдөл нь бие даасан бүтэц бүхий, компьютераар боловсруулах боломжтой болохыг хэлнэ. Бүх өгөгдлүүд нь Үндэсний лавлагаа мэдээллийн санд оруулах ялган таних кодтой байна.
- 5.3. ИЭМЦБ систем болон ГТ-МС-ийн системүүдийн аль алинд нь дараах Эрүүл Мэндийн Лавлагаа Мэдээллийн Сангууд хэрэглэгдэнэ. Үүнд:
- Үйлчлүүлэгч болон тусламж үйлчилгээ үзүүлэгчийн ялган таних лавлагаа мэдээний сан
 - Эм, эмнэлгийн хэрэгслийн ангилалын лавлагаа мэдээний сан
 - Эм, эмнэлгийн хэрэгслийн ялган таних лавлагаа мэдээний сан
 - Лабораторийн шинжилгээ, хариуг ялган таних мэдээний сан
 - Өвчний ангилалын мэдээний сан
 - Эрүүл мэндийн байдлын ба тулгамдсан асуудлын ангилалын мэдээний сан
 - Мэс засал, мэс ажилбарын ангилалын мэдээний сан
 - Үр дүнгийн ангилалын мэдээний сан
 - Өөр өөр ялган танигч, ангиллын хооронд харгалзуулах

6. Өгөгдлийн сангийн агуулга

- 6.1. ИЭМЦБ-ийн систем нь өгөгдөл цуглуулах бодлогын дагуу дараах үндсэн өгөгдлүүдтэй байна.
- 6.1.1. *Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд оролцогч талууд* нь тусламж үйлчилгээ үзүүлэгч байгууллага, эмч, эмнэлгийн мэргэжилтэн, үйлчлүүлэгч хамаарна.
- 6.1.2. *Эрүүл мэндийн байдалд* нь тохирох оношийн код хамаарна.
- 6.1.3. *Эрүүл мэндийн тулгамдсан асуудлууд* тохирох эрүүл мэндийн тусламж үйлчилгээний ангилалын код тухайлбал, эрүүл мэндийн байгууллагад хандсан шалтгаан, онош, хүсэлт, захиргааны үйл ажиллагаа гэх мэт
- 6.1.4. *Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ ба элементүүд* дараах эрүүл мэндийн тусламж үйлчилгээний элементүүдийн ялган таних эсхүл ангиллын код хамаарна.
- 6.1.5. *Эрүүл мэндийн оношилгоо* –ны үйл ажиллагаанууд лабораторийн шинжилгээ болон дүрс оношилгооны ажилбарууд хамаарна
- 6.1.6. *Эмчилгээ гэдэгт мэс засал болон бусад эрүүл мэндийн тусламж үйлчилгээний ажилбарууд* хамаарна.
- 6.1.7. *Өөрөө өөртөө тусламж үзүүлэх үйлчилгээ* –гэрээр хэрэглэх эмийн эмчилгээ
- 6.2. *Тусламж үйлчилгээний хариуцлагатай* холбоотой стандартчилсан өгөгдөл нь дээр дурдсан өгөгдлийн тухай үзэл баримтлалаас ялгаатай бөгөөд энэ нь өвчтөнд тусламж үйлчилгээ үзүүлэх явцын аль ч үед эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгч эрх, үүрэг хүлээх тухай бөгөөд цахим шилжүүлэг эсвэл бусад ажилбартай холбоотойгоор шилжүүлж болох хариуцлага тул ИЭМЦБ-д өвчтөний эрүүл мэндийн байдалтай холбоотой мэдээлэл нь тусламж үйлчилгээний үргэлжлэх хугацааны турш дахь хариуцлагын талаарх

мэдээллээс ялгаатай. Эдгээр мэдээлэл нь өөр өөр тусламж үйлчилгээ бүрийн үргэлжлэх байдал, холбоог зохицуулах; тусламж үйлчилгээ үзүүлэгчийг ялган таних ба бусад стандартчлагдсан хяналтын мэдээллүүдээр дамжуулан цуглуулагдана.

- 6.3.** *Тусламж үйлчилгээний үр дүн* гэдэгт эмнэлзүйн үр дүн, эрүүл мэндийн байдал, эмнэлзүйн захиргааны шийдвэрүүд болон эдийн засгийн бүх л төрлийн үр дүнг хамааруулна.
- 6.4.** ИЭМЦБ-ийн систем нь *тусламж үйлчилгээний тасралтгүй байдал (contsys)* загварчлалын хүрээнд хамаарах бүх өгөгдлийг хамаарах бөгөөд Үндсэн өгөгдлийн сангийн тусламж үйлчилгээнд оролцогч талуудыг ялган таних болон тусламж үйлчилгээний ЭПИСОДУУДАД хамаарах эмнэлзүйн удирдлагын эрх, үүрэг олгох хяналтын механизмын үзүүлэлтээр хязгаарлагдахгүй.

7. Баримт бичиг хадгалах мэдээний сангийн агуулга

7.1. Гуравдагч талын Эмнэлгийн цахим бүртгэлийн баримт бичгүүд

- 7.1.1.** ГТ-ын ЭЦБ-ийн систем нь эмч, эмнэлгийн мэргэжилтний өвчтөн үзүүлсэн амбулаторын болон хэвтүүлэн эмчилсэн тусламж үйлчилгээний ЭЦБ-ийн өгөгдлийг HL7 стандартад нийцүүлэн ИЭМЦБ-ийн системд илгээнэ.
- 7.1.2.** ГТ-ын ЭЦБ-ийн систем өгөгдөл нь цахим баримт бичиг солилцох стандартын дагуу ИЭМЦБ-ийн Үндсэн өгөгдлийн мэдээний сан руу нэгтгэгдэнэ.
- 7.1.3.** ГТ-ын ЭЦБ-ийн системээс дараах мэдээллүүдийг илгээнэ. (Хавсралтаас харна уу) Үүнд:
- Эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн тухай тэмдэглэл
 - Амбулаторын эмчийн үзлэгийн тэмдэглэл
 - Яаралтай тусламж үзүүлсэн тэмдэглэл
 - Лабораторын шинжилгээний хариу болон дүрс оношилгооны зурган файлууд хамаарна.

7.2. Хавсаргасан тусгай файлууд

- 7.2.1.** Өгөгдөл цуглуулах бодлогын хүрээнд хамрагдаагүй болон Үндсэн өгөгдлийн мэдээний санд хадгалагдахгүй өгөгдлүүдийг Хавсаргасан тусгай файл хэлбэрээр ИЭМЦБ-д хадгалагдана. Хавсаргасан тусгай файлууд нь энэхүү журмын шаардлагад нийцсэн байна.
- 7.2.2.** Хавсаргасан тусгай файлууд нь эмнэлзүйн уялдаа холбоо бүхий мэдээллүүдтэй холбогдоно.
- 7.2.3.** Хавсаргасан тусгай файлууд ИЭМЦБ-ийн өгөгдөл солилцооны вэб сервисээр дамжуулан ГТ-МС-ийн системээс ИЭМЦБ рүү илгээгдэнэ.
- 7.2.4.** Хавсаргасан тусгай файлд дараах баримт бичгүүд орно. Үүнд:
- Эрүүл мэндийн тайлан мэдээ ирүүлэх журмын хүрээнд цуглуулах шаардлагатай хэдий ч стандартчлагдах боломжгүй хавсарган илгээж буй бүхий л эрүүл мэндийн баримт бичгүүд

- Эмнэлзүйн шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх хэдий ч стандартчлагдах боломжгүй хавсарган илгээж буй бүхий л эрүүл мэндийн баримт бичгүүд зэрэг орно.

7.3. Эмнэлзүйн захиргааны баримт бичиг болон гэрчилгээ

7.3.1 ИЭМЦБ-ийн цахим мэдээллийн хэсэгт дараах Эмнэлзүйн захиргааны баримт бичгүүд эмнэлгийн цахим баримт бичиг (Electronic Medical Document, HL7 CDA/FHIR) форматаар байршина. Үүнд:

- ИЭМЦБ-ийн систем болон ГТ-МС-ээс гаргах лавлагаа тусламж үйлчилгээний шилжүүлгийн тэмдэглэл
- ИЭМЦБ-ийн систем болон ГТ-МС-ээс гаргах Цахим жор
- Бусад эмнэлгийн гэрчилгээ зэрэг эмнэлзүй захиргааны баримт бичгүүд (хавсаргасан тусгай файл хэлбэрээр)

8. Хандалт

- 8.1. ИЭМЦБ-ийн хэрэглэгчийн хандах эрхийн зохицуулалт нь Иргэн болон тусламж үйлчилгээ үзүүлэгч эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд нь үндэсний цахим тоон гарын үсгийн төхөөрөмж ашиглан ИЭМЦБ-д нэвтрэх хүсэлт гаргах үед тоон гарын үсгийг шалгах цахим үйлчилгээ болох SSO (Single sign on) оор баталгаажуулснаар нэвтрэх эрх олгогдно. Энэ нь ИЭМЦБ-ийн мэдээлэл рүү хандаж, ашиглах эрх болно.
- 8.2. ИЭМЦБ-ийн систем дэх тусламж, үйлчилгээний эрх шилжүүлэх удирдлагын зохицуулалт, хэрэглэгчийн эрх, хандалтын дүрмээс хамаарсан нууцлал, аюулгүй байдлын хамгаалалттай уялдана.
- 8.3. ИЭМЦБ-ийн системийн эмчийн портал нь бүх анхан шатны тусламж үйлчилгээний эпизодууд болон тусламж үйлчилгээний тасралтгүй байдал (CONTSYS)-ын стандартчлагдсан өгөгдлүүдэд хандах эрхийг зөвхөн тухайн үйлчлүүлэгчид эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх эрх бүхий өрх, сумын эмчид олгоно.
- 8.4. ИЭМЦБ-ийн системийн эмчийн порталаар төрөлжсөн мэргэжлийн эмч дараах өгөгдөл рүү хандах эрхтэй байна. Үүнд: Төрөлжсөн мэргэжлийн амбулаторийн тусламж үйлчилгээний эпизод болон тусламж үйлчилгээний тасралтгүй байдал (contsys) стандартчлагдсан өгөгдлүүд, түүнчлэн цахим шилжүүлгийн үед үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн хураангуй түүх зэрэг болно.
- 8.5. Лавлагаа шатлалын нарийн мэргэжлийн амбулаторын болон хэвтүүлэн эмчлэн тусламж үзүүлж байгаа эмч нар ЭЦБ-ийн өгөгдлийг ИЭМЦБ-ийн систем рүү илгээхдээ ГТ-МС-ээр дамжуулна. ГТ-МС систем нь энэхүү журмын шаардлагыг хангасан байх бөгөөд журамд нийцсэн гэсэн гэрчилгээ авсан байх шаардлагатай.

БҮЛЭГ III. ЭМНЭЛГИЙН ЦАХИМ БҮРТГЭЛИЙН СИСТЕМИЙН ӨГӨГДӨЛ СОЛИЛЦООНЫ ТЕХНИКИЙН ШААРДЛАГА

1. Зорилго

- 1.1. Энэхүү техникийн шаардлагын зорилго нь үндэсний түвшинд бүрэн харилцан үйлчлэлцэл бүхий мэдээллийг цуглуулах, хуваалцах, солилцохын тулд ИЭМЦБ-ийн системийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг болох эмнэлгийн цахим бүртгэл (ЭЦБ) болон түүний өгөгдөл, функц үйл ажиллагааг тодорхойлох, бий болгоход оршино.
- 1.2. Энэхүү баримт бичиг нь ИЭМЦБ-ийн системийн шаардлагад нийцсэн, эрүүл мэндийн тасралтгүй, цогц тусламж үйлчилгээний зохион байгуулалтын зарчмуудыг дэмжсэн, санд өгөгдлөө нэгтгэх боломжтой ЭЦБ-ийг бий болгох юм.

2. Мэдээллийг нэгтгэх

- 2.1. ЭЦБ гэдэг нь анхан болон лавлагаа шатлалын тусламж үйлчилгээ үзүүлэгч эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн өвчнийг оношлох, эмчлэх зорилгоор үйлчлүүлэгчид үзүүлсэн эмнэлгийн тусламж үйлчилгээнүүдийн бүртгэлийг хэлнэ.
- 2.2. ИЭМЦБ нь анхан шатны тусламж үйлчилгээнд суурилсан үйлчлүүлэгч төвтэй, харилцан үйлчлэлцэл бүхий хамтын ажиллагаа, тусламж үйлчилгээний тасралтгүй цогц байдлыг хангахад дэмжлэг үзүүлдэг бол ЭЦБ нь өвчинд суурилсан, салангид шинжтэй. Иймд ЭЦБ нь мэдээлэл дамжуулах, хуваалцах харилцан үйлчлэлцэл бий болгохын тулд ИЭМЦБ-ийн системд мэдээллээ нэгтгэх шаардлагатай.
- 2.3. ЭЦБ-ийн систем нь ИЭМЦБ-ийн систем рүү мэдээллээ нэгтгэхийн тулд ИЭМЦБ-ийн системийн бүтэц болон зохион байгуулалтын шаардлагад нийцүүлэн мэдээллээ дамжуулах ёстой. Ингэснээр өвчинд бус өвчтөнд суурилах ИЭМЦБ-ийн системийн шаардлагад нийцнэ.
- 2.4. Гуравдагч талын ЭЦБ-ийн системд төр, хувийн хэвшлийн анхан болон лавлагаа шатлалын эмнэлгүүдийн цахим бүртгэлийн системүүд орно.
- 2.5. Эрүүл мэндийн мэдээлэл солилцооны платформ(ЭММСП)-ын Мэдээлэл дамжуулах интерфэйс нь Гуравдагч талын ЭЦБ-ийн системтэй HL7-ийн баримт бичиг дамжуулах стандартад нийцүүлэн мэдээллийг хувиргаж ИЭМЦБ-ийн системтэй өгөгдөл солилцох юм.
- 2.6. ЭЦБ-ийн систем нь ЭММСП-ийн мэдээлэл дамжуулах интерфэйсээр ЭЦБ-ийн стандартчлагдсан өгөгдлүүдийг ИЭМЦБ-д илгээнэ.
- 2.7. ИЭМЦБ-ийн системээс ЭММСП-ийн мэдээлэл дамжуулах интерфэйсээр ИЭМЦБ-ийн санд хадгалагдаж буй стандартчлагдсан өгөгдлүүдийг ЭЦБ-ийн системд хүлээн авч, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгч эмнэлгийн мэргэжилтэнд харуулах интерфэйстэй байна.

3. Зохион байгуулалтын харилцан үйлчлэлцлийг хангах

- 3.1. ИЭМЦБ-ийн системийн зохион байгуулалтын харилцан үйлчлэлцлийг ISO13940 стандартын тусламж үйлчилгээний тасралтгүй, цогц байдал (CONTSYS)¹-ын үзэл санаа, нэр томъёололыг хэрэгжүүлж, бүх түвшинд үйлчлүүлэгчийн зөв зохион байгуулагдсан, стандартчилсан мэдээллийг бий болгоно.
- 3.2. ЭЦБ-ийн систем нь харилцан үйлчлэлцлийг хангахын тулд ИЭМЦБ-ийн системд өгөгдлүүдийг нэгтгэхдээ утга зүйн уялдаа холбоотойгоор байршуулах шаардлагатай. Үүний тулд дараах зохион байгуулалтын хэрэгслүүдийг ашиглана. Үүнд:
 - 3.2.1. Тусламж үйлчилгээний тасралтгүй, цогц байдлын Үйлчлүүлэгч төвтэй өгөгдлийн удирдлагын үзэл санааг нэвтрүүлэх
 - 3.2.2. Тусламж үйлчилгээний тасралтгүй, цогц байдлын Эрүүл мэндийн тусламжийн эрх, үүргийн удирдлагыг хэрэгжүүлэх
 - 3.2.3. Тусламж үйлчилгээний эписодыг зөв зохистой удирдахад шаардлагатай эрүүл мэндийн тусламжийн эрх, үүргийн удирдлагыг цахим шилжүүлгийн журмаар хэрэгжүүлэх
 - 3.2.4. Тусламж үйлчилгээний эписод нь бүтэц, агуулгын хувьд харилцан уялдаа холбоотойгоор стандарчлагдсан байх бөгөөд Гуравдагч талын мэдээллийн систем болон ИЭМЦБ-ийн систем хоорондоо мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлэх
 - 3.2.5. Тусламж үйлчилгээний эписодын утга зүйн зохион байгуулалт гэдэг нь тодорхой цаг хугацааны туршид болон тусламж үйлчилгээний шатлал бүрт бий болох эписодыг харгалзуулах(nested) хэлбэрээр зохион байгуулах
- 3.3. Гуравдагч талын ЭЦБ-ийн системийн зохион байгуулалтын харилцан үйлчлэлцэл нь эдгээр системүүд өөрсдийн өгөгдлөө эмнэлгийн цахим бичгүүд хэлбэрт (хавсралтын дагуу) оруулан ИЭМЦБ-ийн системтэй өгөгдөл солилцоход дараах шаардлагад нийцсэн байна.
- 3.4. Гуравдагч талын ЭЦБ-ийн систем нь эмнэлгийн цахим баримт бичгүүдийг илгээхдээ олон улсын HL7 стандартад нийцүүлсэн байна.
- 3.5. ИЭМЦБ-ийн систем рүү илгээх Гуравдагч талын ЭЦБ-ийн системийн эмнэлгийн цахим баримт бичгүүдийн өгөгдлийн агуулга нь энэхүү баримт бичигт заасан өгөгдлийн бүтэц, зохион байгуулалт, харилцан үйлчлэлцлийн шаардлагыг хангасан байна.

4. Бүтцийн харилцан үйлчлэлцлийг хангах

- 4.1. Гуравдагч талын ЭЦБ-ийн систем нь 14 дугаарт заасан өгөгдлийн бүтцийн шаардлага болон ИЭМЦБ-ийн тусламж үйлчилгээний тасралтгүй

¹ Тусламж үйлчилгээний тасралтгүй, цогц байдлын цахим стандарт CONTSYS.org

байдлын шаардлагад нийцүүлэн өгөгдлөө ИЭМЦБ-ийн системтэй солилцоход зохион байгуулалтын харилцан үйлчлэлцлийг хангана.

4.2. Гуравдагч талын ЭЦБ-ийн систем нь бүтцийн харилцан үйлчлэлцэл бүхий дараах баримт бичгүүдийг цахим шилжүүлгийн баримт бичгийн дагуу солилцоно. Үүнд:

4.2.1. Хэвтэн эмчлүүлсэн тухай тэмдэглэл

4.2.2. Амбулаторийн эмчийн үзлэгийн тэмдэглэл

4.2.3. Яаралтай тусламж үзүүлсэн тэмдэглэл

4.3. ЭЦБ-ийн систем нь өгөгдлөө ИЭМЦБ-ийн системийн өгөгдлийн бүтцийн стандартын дагуу эмнэлгийн цахим баримт бичиг хэлбэрээр дамжуулна.

4.4. ИЭМЦБ-ийн систем нь Гуравдагч талын Мэдээллийн системээс ирүүлсэн цахим баримт бичгүүдийн хүлээн авч, тусламж үйлчилгээний тасралтгүй, цогц байдлын бүтэцтэй уялдуулан ИЭМЦБ-ийн шаардлагад нийцсэн өгөгдөл болгон хувиргана.

4.5. Зохион байгуулалтын утга зүй талаас нь авч үзвэл лавлагаа (Хоёрдогч болон гуравдагч) шатлалд амбулаторын болон хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээ үзүүлж байгаа эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн үзүүлсэн Тусламж үйлчилгээний эпизодууд нь ЭЦБ-ийн системийн тусламж үйлчилгээний тасралтгүй байдалтай (CONTSYS) уялдсан бүтэц байна. ИЭМЦБ-ийн системийн шаардлагын дагуу бүх түвшний утга зүйн харилцан үйлчлэлцлийг (зохион байгуулалт, бүтэц, өгөгдлийн) хангахын тулд эдгээр тусламж үйлчилгээний эпизодууд нь харгалзах анхан шатны тусламж үйлчилгээний Эпизодууд дотор эмнэлзүй үйл явцтай харилцан уялдан, хоорондоо холбоотой байршина.

4.6. Хадгалагдаж буй бүртгэлүүдийн эмнэлзүйн уялдааг хангах, мэдээллийн аюулгүй байдал, нууцлалыг сахих, тасралтгүй, цогц тусламж үйлчилгээг үр дүнтэйгээр дэмжих, ИЭМЦБ-ийн системд ЭЦБ-ийн Тусламж үйлчилгээний эпизодуудыг хоорондоо холбоотой байршуулах зэрэг нь энэ баримт бичгийн 14 дугаар заалт болон ИЭМЦБ-ийн системийн техникийн шаардлагын баримт бичгийн хүрээнд зохицуулагдана.

4.7. Лавлагаа шатлалд яаралтай тусламжаар эмнэлэгт хандсан тохиолдолд тусламж үйлчилгээ үзүүлж байгаа эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн үзүүлсэн тусламж үйлчилгээний эпизодууд нь анхан шатны эпизод үүсгэсэн эсэхээс үл хамааран ИЭМЦБ-ийн системийн эпизодууд дотор эмнэлзүйн үйл явцтай харилцан уялдан, байршина.

5. Өгөгдөл цуглуулах бодлогыг хангах

5.1. Өгөгдөл цуглуулах бодлогын дагуу ИЭМЦБ-ийн систем дэх эмнэлзүйн өгөгдлүүд нь бүрэн цахимжсан байх ёстой хэдий ч одоогийн мөрдөж буй эрх зүйн шаардлагыг хангахын тулд харилцан үйлчлэлцэлийн шаардлага хангахгүй өгөгдлүүд нь ИЭМЦБ-ийн системийн Үндсэн өгөгдлийн санд (CDB)-

д эмнэлгийн цахим баримт бичгүүд (EMD) хэлбэрээр хадгалагдана. Энэхүү Өгөгдөл цуглуулах бодлого нь шаардлагагүй, хор хөнөөлтэй, түвэгтэй байдлыг бий болгохгүйгээр эмнэлзүйн шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх стратеги дээр тулгуурласан. Цаашид Өгөгдөл цуглуулах бодлогын хүрээнд ИЭМЦБ-ийн систем дэх эмнэлгийн цахим баримт бичгүүдийг бүрэн цахимжсан, харилцан үйлчлэлцэл бүхий дискрет өгөгдөл хэлбэрээр үндсэн өгөгдлийн санд цуглуулахад аажмаар шилжинэ.

5.2. Энэхүү баримт бичигт ЭЦБ-ийн системийн өгөгдөлтэй холбоотой дараах Өгөгдөл цуглуулах бодлого баримтална. Үүнд:

5.2.1. ИЭМЦБ-ийн системийн буй өгөгдлүүд нь аль болох техникийн шаардлагад тусгагдсан дискрит, бүрэн цахимжсан хэлбэртэй байна.

5.2.2. ИЭМЦБ-ийн техникийн шаардлагад тодорхойлсон “Эрүүл мэндийн асуудал” нь өвчний оношоор илэрхийлэгдэх ба ӨОУА-10 дагуу кодолсон байна. Энэ ойлголтын хүрээнд хэвтэх үеийн онош, үндсэн онош, гарах үеийн онош зэрэг хэд хэдэн төрлийн онош агуулагдаж болно.

5.2.3. “Эрүүл мэндийн байдал” нь эрүүл мэндийн асуудлуудын нэгийг нь тусламж үйлчилгээний эписодын болон оношоор ялган таних процессын одоогийн төлөв байдал болгон авна.

6. Өгөгдлийн харилцан үйлчлэлцлийг хангах

6.1. Дискрет, бүрэн цахимжсан өгөгдөл илгээх зорилготой өгөгдлийн харилцан үйлчлэлцлийн шаардлагын дагуу Гуравдагч талын ЭЦБ-ийн систем нь эмнэлгийн цахим баримт бичгийг өөрийн системээс ИЭМЦБ-ийн систем рүү дамжуулахдаа Өгөгдөл цуглуулах бодлогын дагуу хэрэглэх эмнэлзүйн өгөгдлийг ялган таних, ангилах стандартуудыг ашиглана.

6.2. 25 дах заалтыг хэрэгжүүлэхийн тулд Гуравдагч талын ЭЦБ-ийн системийн өгөгдөл нь ИЭМЦБ-ийн техникийн шаардлагад заасан Эрүүл мэндийн Лавлагаа мэдээний сангийн стандартыг ашиглан цуглуулагдсан байна.

7. Өгөгдлийн сангийн агуулга

7.1. ЭЦБ-ийн системээс өгөгдлүүд бүрэн стандартчлагдсан өгөгдөл цуглуулах бодлогын дагуу ИЭМЦБ-ийн системийн Үндсэн өгөгдлийн санд цуглуулж, дамжуулагдана.

8. Баримт бичгийн сан

8.1. Гуравдагч талын Эмнэлгийн цахим бүртгэл

8.1.1. ИЭМЦБ-ийн техникийн шаардлагын дагуу Гуравдагч талын Мэдээллийн системээс хүлээн авсан болон ИЭМЦБ-ийн системийн бий болгосон эмнэлгийн цахим баримт бичгүүд нь ИЭМЦБ-ийн системийн Цахим баримт бичгийн санд хадгалагдах бөгөөд Үндсэн өгөгдлийн сантай холбогдоно.

- a. Лавлагаа (Гуравдагч болон хоёрдогч) шатлалын эмнэлэгт хэвтүүлэн эмчилсэн тухай тэмдэглэл- энэ нь Тусламж үйлчилгээний эпизодууд хэлбэртэй байх ба эмнэлэгт хэвтэхээс гарах хүртэлх мэдээллийг багтаасан ЭЦБ байна.
- b. Амбулаторын төрөлжсөн мэргэжлийн тусламж үйлчилгээ үзүүлсэн эмчийн тэмдэглэл, үр дүнгүүд- эдгээр нь тусламж үйлчилгээний тасралтгүй байдлын стандартад тодорхойлсон утга зүйн зохион байгуулалтын дагуу эрүүл мэндийн нэг асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн тусламж үйлчилгээнүүд (энкаунтер) бүрийг тодорхойлоход шаардлагатай бүх өгөгдлүүдийг агуулсан байна.
- c. Оношилгоо, шинжилгээний үр дүн- эмнэлэгт хандах тохиолдолд бүрт хийгдсэн дүрс оношилгооны файлууд болон лабораторын шинжилгээний үр дүнгүүд нь тухайн харгалзах энкаунтеруудтай холбогдоно. ЭЦБ-ийн системийн оношилгооны үр дүнгийн файлууд нь Үндэсний PACS системд байрлаж, ИЭМБ-ийн системийн үндсэн өгөгдөлтэй холбогдож ашиглагдана. ЭЦБ-ийн лабораторийн шинжилгээний үр дүнгүүд нь LOINC олон улсын стандартын дагуу кодлогдож эмнэлгийн цахим баримт бичиг эсвэл хавсаргасан тусгай файл хэлбэрээр ИЭМЦБ-ийн систем рүү илгээгдэж үндсэн өгөгдөлд байршина.

8.2. Хавсаргасан тусгай файлууд

8.2.1. ИЭМЦБ-ийн системийн 7.2 дах бүлэг заалтууд хамаарна.

8.2.2. Эрх бүхий этгээдийн хүсэлтээр Хавсаргасан тусгай файлууд ИЭМЦБ-ийн өгөгдөл солилцооны вэб сервисээр дамжуулан Гуравдагч талын мэдээллийн системээс ИЭМЦБ рүү илгээгдэнэ.

8.3. Эмнэлзүйн захиргааны баримт бичиг болон гэрчилгээнүүд

8.3.1. ИЭМЦБ-ийн системийн 7.3 дах бүлэг заалтууд хамаарна.

БҮЛЭГ IV. ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНД ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫГ ЯЛГАН ТАНИХ ТЕХНИКИЙН ШААРДЛАГА

1. Зорилго, зорилтууд

1.Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд оролцогч талуудыг ялган таних бүртгэлийн өгөгдлийг Үндэсний лавлагаа мэдээллийн санд оруулж, Эрүүл мэндийн салбарын мэдээлэл солилцох платформоор дамжуулан ИЭМЦБ болон эмнэлгийн цахим бүртгэлийн системүүд хооронд мэдээллийг солилцох, ашиглах боломжийг бүрдүүлнэ.

- 1.1. Үйлчлүүлэгч, тусламж үйлчилгээ үзүүлэгч эмч, эмнэлгийн мэргэжилтэн болон байгууллагын ялган танигч, бүртгэлийг бий болгох
- 1.2. Ялган танихад хэрэглэгддэг өгөгдлийн бүтцийн олон улсын стандартыг өөрийн орны онцлогтой уялдуулан нэвтрүүлэх
- 1.3. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд оролцогч талуудын Ялган таних бүртгэлийг ЭММСП-оор дамжуулан эрх бүхий цахим эрүүл мэндийн системүүдэд ашиглах боломжийг бүрдүүлэх

2 Ерөнхий зүйл

- 2.1. Үйлчлүүлэгч, эмч эмнэлгийн мэргэжилтэн, байгууллагын ялган таних бүртгэлүүд нь Үндэсний лавлагаа мэдээний санд байршина.
- 2.2. Эрүүл мэндийн хөгжлийн төв нь үйлчлүүлэгч, тусламж үйлчилгээ үзүүлэгч эмч, эмнэлгийн мэргэжилтэн, байгууллагын ялган таних бүртгэл бий болгох, үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах, шинэчлэх үүргийг хүлээнэ.
- 2.3. Үйлчлүүлэгч, эмч эмнэлгийн мэргэжилтэн, тусламж үйлчилгээ үзүүлэгч байгууллагыг ялган таних бүртгэл дараах лавлагаа үйлчилгээг үзүүлнэ. Үүнд:
 - а/ ИЭМЦБ болон эмнэлгийн цахим бүртгэлийн системээс ирүүлсэн хүсэлтийн дагуу үйлчлүүлэгч, эмч эмнэлгийн мэргэжилтэн, байгууллагыг ялган таних,
 - б/ хүсэлт илгээж байгаа эмнэлгийн цахим бүртгэлийн системийг үйлчлүүлэгч, эмч эмнэлгийн мэргэжилтэн, байгууллагын талаарх лавлагаа мэдээллээр хангах үйлчилгээ үзүүлнэ.
- 2.4. Цахим эрүүл мэндийн систем хооронд эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд оролцогч талуудыг ялган таних өгөгдлүүдийн дамжуулалт нь олон улсын HL7 CDA стандарт ашиглаж эрүүл мэндийн мэдээлэл солилцооны платформ дээр хийгдэнэ.

3. Үйлчлүүлэгчийг ялган таних

- 3.1. Үйлчлүүлэгчийг ялган танигч дугаар нь Улсын Бүртгэлийн Ерөнхий Газраас Монгол улсын иргэнд олгодог Регистерын дугаар байна.
- 3.2. Үйлчлүүлэгчийн ялган таних бүртгэлд нь дараах мэдээллүүд хамаарна.
 - 3.2.1. Үйлчлүүлэгчийн ялган танигч

- 3.2.2. Тухайн үйлчлүүлэгчийн ялган таних дугаар идэвхтэй байгаа эсэх
 - 3.2.3. Үйлчлүүлэгчийн нэр
 - 3.2.4. Үйлчлүүлэгчийн төрсөн он сар өдөр
 - 3.2.5. Үйлчлүүлэгчийн хүйс
 - 3.2.6. Үйлчлүүлэгчийн нас барсан он сар өдөр
 - 3.2.7. Үйлчлүүлэгчийн фото зураг
 - 3.2.8. Үйлчлүүлэгчийн хаягийн мэдээлэл
 - 3.2.9. Үйлчлүүлэгчийн цахим хаягийн мэдээлэл
 - 3.2.10. Үйлчлүүлэгчийн ойр дотны холбоо барих хүмүүсийн мэдээлэл
- 3.3. Энэхүү журамд заасны дагуу үйлчлүүлэгчийн ялган таних дугаар болон ялган таних мэдээлэлд тулгуурлан үйлчлүүлэгчийн бүх мэдээлэл ИЭМЦБ-ийн системд бүртгэгдэж, хадгалагдаж, солилцож, ашиглагдаж байна.
- 3.4. ИЭМЦБ-ийн систем нь Үндэсний Лавлагаа Мэдээллийн Систем дэх Үйлчлүүлэгчийн Ялган Таних Бүртгэлийг ашиглан үйлчлүүлэгчийн ялган таних мэдээлэл, тэдгээрт гарсан өөрчлөлтийг тодорхой давтамжтайгаар автоматаар шинэчлэнэ.
- 3.5. Үйлчлүүлэгчийг ялган таних бүртгэлийн өгөгдлийн бүтэц, түүнд тавигдах техникийн шаардлагыг Хавсралт 7-д зааснаар тодорхойлно.
- 3.6. Үйлчлүүлэгчийг Ялган Таних Бүртгэлийн систем дэх Үйлчлүүлэгчийн ялган таних болон хувийн мэдээллийн нууцлал, аюулгүй байдал нь Цахим эрүүл мэндийн нууцлал, аюулгүй байдлын журам, хуулиар зохицуулагдана.

4. Эмч, эмнэлгийн мэргэжилтнийг ялган таних

- 4.1. Тусламж үйлчилгээ үзүүлэгч эмч, эмнэлгийн мэргэжилтний ялган таних дугаар нь эрх бүхий байгууллагаас эмч, эмнэлгийн мэргэжилтэнд олгосон мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн дугаар буюу системээс олгосон дахин давтагдашгүй дугаар байна.
- 4.1.1. Тусламж үйлчилгээ үзүүлэгч эмч, эмнэлгийн мэргэжилтнийг ялган таних бүртгэлд дараах мэдээллүүд хамаарна.
 - 4.1.2. Тусламж үйлчилгээ үзүүлэгчийг ялган танигч
 - 4.1.3. Тухайн тусламж үйлчилгээ үзүүлэгч эмч, эмнэлгийн мэргэжилтний ялган таних дугаар идэвхтэй байгаа эсэх
 - 4.1.4. Нэрний мэдээлэл
 - 4.1.5. Төрсөн он сар өдөр
 - 4.1.6. Хүйс
 - 4.1.7. Фото зураг
 - 4.1.8. Хаягийн мэдээлэл

- 4.1.9. Цахим хаягийн мэдээлэл
- 4.2. 7.2.9 Эмч, эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа үндсэн чиглэл
- 4.3. 7.2.10 Одоогийн ажил олгогч байгууллага
- 4.4. ИЭМЦБ-ийн болон энэхүү журамд заасны дагуу тусламж үйлчилгээ үзүүлэгч эмч, эмнэлгийн мэргэжилтний ялган таних дугаар болон мэдээллийг ашиглан тухайн үйлчлүүлэгчид тусламж үйлчилгээ үзүүлэх эрх бүхий эмч, эмнэлгийн мэргэжилтэнг тодорхойлсноор ИЭМЦБ-ийн системд бүх мэдээлэл бүртгэгдэж, хадгалагдаж, мэдээлэл солилцож, ашиглагдах ёстой.
- 4.5. ИЭМЦБ-ийн систем нь Үндэсний Лавлагаа Мэдээллийн Систем дэх Тусламж Үйлчилгээ үзүүлэгч эмч, эмнэлгийн мэргэжилтний ялган таних бүртгэлийн системийг ашиглан эмч, эмнэлгийн мэргэжилтний ялган таних мэдээлэл, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, тэдгээрт гарсан өөрчлөлтийг тодорхой давтамжтайгаар автоматаар шинэчилнэ.
- 4.6. Тусламж үйлчилгээ үзүүлэгч эмч, эмнэлгийн мэргэжилтнийг ялган таних бүртгэлийн өгөгдлийн бүтэц, техникийн шаардлагыг Хавсралт 8-д зааснаар тодорхойлно.
- 4.7. Тусламж үйлчилгээ үзүүлэгчийг ялган таних дугаар Тусламж үйлчилгээ үзүүлэгчийг ялган таних мэдээллийг баталгаажуулах зорилготой бөгөөд ИЭМЦБ-ийн системд нэвтрэх эрх биш юм.
- 4.8. Үндэсний лавлагаа мэдээний санд байршиж байгаа Тусламж үйлчилгээ үзүүлэгч эмч, эмнэлгийн мэргэжилтнийг ялган таних бүртгэл дэх мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл нь эмч, эмнэлгийн мэргэжилтний ИЭМЦБ-ийн системд хандах, ашиглах эрхийг зохицуулна.

5. Тусламж үйлчилгээ үзүүлэгч байгууллагыг ялган таних

- 5.1. Байгууллагын ялган таних дугаар нь эрх бүхий байгууллагаас эрүүл мэндийн байгууллагад олгосон бүртгэлийн дугаар байна.
- 5.2. Тусламж үйлчилгээ үзүүлэгч байгууллагыг ялган таних бүртгэлд дараах мэдээллүүд хамаарна. Үүнд:
- 5.2.2. Тусламж үйлчилгээ үзүүлэгчийн ялган танигч
 - 5.2.3. Тухайн тусламж үйлчилгээ үзүүлэгч байгууллагын ялган таних дугаар идэвхтэй байгаа эсэх
 - 5.2.4. Байгууллагын нэр
 - 5.2.5. Байгууллагын регистрийн дугаар
 - 5.2.6. Байгууллагын үйл ажиллагаа эрхлэх хүчин төгөлдөр хугацаа
 - 5.2.7. Байгууллагын хаяг
 - 5.2.8. Байгууллагын цахим харилцаа холбоо
 - 5.2.9. Байгууллагын эрх бүхий холбоо барих хүний мэдээлэл
 - 5.2.10. Байгууллагын мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн талаарх мэдээлэл
 - 5.2.11. Байгууллагын ангилал

- 5.2.12. Байгууллагын төрөл
- 5.2.13. Байгууллагын үйлчилгээ
- 5.2.14. Байгууллагын үзлэгийн кабинетийн төрөл
- 5.2.15. Байгууллагын хэвтүүлэн эмчлэх тасгийн төрөл
- 5.2.16. Байгууллагын үзлэгийн кабинет, хэвтүүлэн эмчлэх тасгийн байршил

5.3. Тусламж үйлчилгээ үзүүлэгч байгууллагын ялган таних дугаар болон холбогдох мэдээллийг ашиглан тухайн үйлчлүүлэгчид тусламж үйлчилгээ үзүүлсэн эрх бүхий байгууллагыг тодорхойлсноор ИЭМЦБ-ийн системд бүх мэдээлэл бүртгэгдэж, хадгалагдаж, мэдээлэл солилцож, ашиглагдах ёстой.

5.4. Тусламж үйлчилгээ үзүүлэгч байгууллагыг ялган таних бүртгэлийн өгөгдлийн бүтэц, техникийн шаардлагыг Хавсралт 9-д зааснаар тодорхойлно.

БҮЛЭГ V. ЦАХИМ ШИЛЖҮҮЛГИЙН ТЕХНИКИЙН ШААРДЛАГА

1. Зорилго, зорилтууд

Эрүүл мэндийн мэдээлэл солилцох платформыг хэрэгжүүлэхэд энд дурдсан цахим эрүүл мэндийн холбогдох стандартуудтай уялдуулан цахим шилжүүлгийг зохицуулах тогтолцоог бий болгох юм.

Баримт бичгийн зорилтууд дараах болно. Үүнд:

1.1. Эрүүл мэндийн тухай хууль болон ИЭМЦБ-ийн системийн тусламж үйлчилгээний тасралтгүй байдлыг дэмжих шаардлагын дагуу цахим шилжүүлгийн үеийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний нөхцөл байдлыг тодорхойлж, зохицуулна. Энэ нь тусламж үйлчилгээ үзүүлэгч лавлагаа тусламж үзүүлэх хүсэлт илгээх буюу шилжүүлэг хийх болон шилжүүлгийг хүлээн авах талаарх нөхцөл байдлыг тодорхойлно.

1.2. ИЭМЦБ-ийн систем дэхь мэдээллийн удирдлагын дагуу зохицуулагдах цахим шилжүүлгийн үр дүнг тодорхойлж, зохицуулна. Үүнд тусламж үйлчилгээний тасралтгүй байдлыг хангахад шаардлагатай мэдээллийн эрх, үүргийн удирдлага, хуваарилалт хамаарна.

1.3. Энэхүү баримт бичгийн ИЭМЦБ-ийн системийн өгөгдөл солилцооны техникийн шаардлагад заасны дагуу заасны дагуу тусламж үйлчилгээний шатлал бүрт өөр өөр шилжүүлгийн үр дүнд үүссэн Тусламж үйлчилгээний эпизодууд, тэдгээрийн байршуулалт ыг тодорхойлж, зохицуулна.

1.4. Лавлагаа шатны тусламж авахаар өвчтнийг цахимаар илгээх, шилжүүлэх цахим маягтын мэдээллийн агуулгыг энэхүү журмаар зохицуулахгүй. Энэ мэдээлэл нь хүсэлт илгээж буй тусламж үйлчилгээний цар хүрээ болон хүлээн авч буй эмнэлгийн мэргэжилтэнд өгөх тусламж үйлчилгээний эрх, үүргийн хэлбэр зэргээс хамаарч эмнэлзүйн болон эмнэлзүй лавлагааны мэдээллийг хоёуланг агуулна.

1.5. Энэхүү баримт бичиг нь Эрүүл мэндийн сайдын тушаалаар баталсан “Эмнэлэг хооронд өвчтөн шилжүүлэх ” журмыг орлоно.

1.6 Дараах стандартууд, баримт бичгүүдийн хүрээнд хэрэгжинэ.Үүнд:

1.6.1. ИЭМЦБ-ийн техникийн шаардлага

1.6.2. ЭЦБ-ийн системийн техникийн шаардлага

1.6.3. Үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн хураангуй мэдээллийн техникийн шаардлага

2. Зарчим

2.1. Энэхүү баримт бичигт хэрэглэгдэх нэр томьёо нь ИЭМЦБ-ийн техникийн шаардлагад заасны дагуу харилцан үйлчлэлцэл бүхий Цахим эрүүл мэндийн систем болон оролцогч талуудыг дэмжих нэр томьёо, үзэл баримтлалын хүрээнд тодорхойлогдоно.

2.2. Цахим шилжүүлэг нь энэ баримт бичгийн ИЭМЦБ-ийн техникийн шаардлагад заасны дагуу тусламж үйлчилгээний тасралтгүй байдлыг хадгалж, зохицуулж, дэмжиж, бэхжүүлж, цаашид үргэлжлүүлэн дэмжих

зорилгоор эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгч нэг байгууллагаас нөгөөд тусламж үйлчилгээний эрх, үүргээ шилжүүлэхийг хэлнэ. Тусламж үйлчилгээний эрх, үүрэг нь ямар ч төрлийн үйлчилгээг хамрах бөгөөд тухайн тусламж үйлчилгээний хамрах хүрээ, хэлбэрийг шилжүүлгийн үед тодорхойлж өгөх ёстой. Үүнд:

- Амбулаторын лавлагаа тусламж үйлчилгээ
- Хэвтүүлэн эмчлэх лавлагаа тусламж үйлчилгээ
- Онош тодруулах, мэс засал болон бусад оношилгоо, эмчилгээний лавлагаа тусламж үйлчилгээ

2.3. ИЭМБЦ-ийн системийн мэдээллийн зохион байгуулалт талаас авч үзвэл, Цахим шилжүүлэг нь цаг хугацаа, тусламж үйлчилгээний шатлалын түвшингүүдэд үйлчлүүлэгчийн ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЭПИСОД-ийн үр дүн, цаашдын зохицуулалтыг бий болгосноор ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЭПИСОД-ууд болон холбогдох бүртгэлүүдийн бүтцүүдийг ИЭМЦБ-ийн систем болон ЭЦБ-ийн системийн өгөгдөл солилцооны техникийн шаардлагад заасны дагуу хооронд нь холбох механизмыг бий болгож эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгчдийн тасралтгүй, үр дүнтэй хамтын ажиллагааг дэмжинэ.

2.4. Ажилбарын захиалга-ИЭМЦБ-ийн систем болон Гуравдагч талын ЭЦБ-ийн системийн аль аль талаас авч үзвэл ажилбар хийлгэх захиалга нь лавлагаа тусламж авах шилжүүлгээс ялгаатай. Ажилбарын захиалга хийхэд тусламж үйлчилгээ үзүүлэх эрх, үүрэг олгогдох боловч Тусламж үйлчилгээний эпизод үүсэхгүй. ИЭМЦБ болон Гуравдагч талын мэдээллийн системд захиалгын тэмдэглэл нь цахим шилжүүлгийн тэмдэглэлтэй адилхан үүсгэгдэх боловч амбулаторийн болон хэвтүүлэн эмчлэх лавлагаа тусламжийн шилжүүлгээс ялгаатай нь уг процессын үр дүн тухайн захиалсан үйлчилгээтэй холбоотой мэдээллийг цуглуулах, баримтжуулах юм. Үйлчилгээний үр дүн нь ИЭМЦБ-ийн системд эрүүл мэндийн тусламжийн үйл ажиллагааг баримтжуулах 6.1, 6.2 заалтуудад нийцсэн байх ба үүнд оношилгооны үр дүн мөн хамаарна.

2.8. ИЭМЦБ ба түүний өгөгдлийн бүтцийн зохион байгуулалтын утга зүй (семантик)-н суурь зарчмуудыг хэрэгжүүлэхийн тулд эрүүл мэндийн үйл ажиллагаанууд(healthcare activity)-ын бүх бүртгэлүүд хийсвэрлэлийн хамгийн дээд түвшин буюу өвчтөн болон хамгийн доод түвшин буюу өвчин, хүндрэл, эсвэл хэзээ нэг цагт эмчлэгдсэн эмгэгийн түвшин дэхь эмнэлзүйн өөрчлөлтийг тусгасан байх ёстой. Агуулгын энэ зарчмыг хийсвэрлэлийн янз бүрийн түвшингүүд дэхь ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЭПИСОД-ийн байршуулалтаар (nesting) хэрэгжих бөгөөд ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЭПИСОД-ийн хамгийн дээд түвшин нь үйлчлүүлэгчийн амьдралын хугацаанд байна. Шилжүүлэгтэй холбоотой үүсч, байршуулах дараах ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЭПИСОД-ийн түвшин байна. Үүнд:

2.8.1. Түвшин 1: Анхан шатны тусламж үйлчилгээний түвшин дэх ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЭПИСОД. Энэ нь уг эпизодын хүрээнд төрөлжсөн мэргэжлийн тусламжийн шилжүүлэг хийх үед үйлчлүүлэгчийн тухайн эрүүл мэндийн байдалд хамаарах нөхцөл байдлын мэдээллээр хангана.

2.8.2. Түвшин 2. Анхдагч шатны тусламж үйлчилгээ үзүүлэгчээс лавлагаа (Хоёрдогч) шатлалын амбулаторын тусламж авахаар үйлчлүүлэгчийг илгээсэн тохиолдолд лавлагаа шатлалын амбулаторын Тусламж үйлчилгээний эписод үүснэ.

2.8.3. Түвшин 3. Лавлагаа (Хоёрдогч) шатны тусламж үйлчилгээ үзүүлэгчээс төрөлжсөн мэргэжлийн (Гуравдагч) амбулаторын лавлагаа тусламж авахаар үйлчлүүлэгчийг илгээсэн тохиолдолд төрөлжсөн (Гуравдагч) мэргэжлийн амбулаторын тусламж үйлчилгээний эписод үүснэ.

2.8.4. Түвшин 4. Төрөлжсөн мэргэжлийн (Гуравдагч) амбулаторын тусламж авч байгаад хэвтүүлэн эмчлэх тохиолдолд төрөлжсөн мэргэжлийн шатлалд үйлчлүүлэгчийн хэвтүүлэн эмчлэх Тусламж үйлчилгээний эписод үүснэ.

2.8.5. Төрөлжсөн мэргэжлийн шатлалд хэвтүүлэн эмчлэх лавлагаа тусламж үйлчилгээ үзүүлэх үед үүссэн хүндрэлийг эмчлэх холбоотойгоор хүндрэлийг эмчлэх Тусламж үйлчилгээний эписод үүснэ.

3. Ерөнхий шаардлага

3.1. Энэ баримт бичигт тодорхойлсны дагуу эрүүл мэндийн тусламж үйлчилгээний эрх, үүргийн удирдлага, хуваарилалтын механизм нь ИЭМЦБ-ийн системийн нэг бүрэлдэхүүн хэсэг байж цахим бүртгэлүүдийн зохистой бүтэц, зохион байгуулалтын семантикийг хангах, цахим шилжүүлгийн зөв удирдлага, зохицуулалтыг хангана.

3.2. Эрүүл мэндийн тусламж үзүүлэгч нь ИЭМЦБ-ийн систем техникийн шаардлагад заасны дагуу заасны дагуу эрүүл мэндийн тусламж үзүүлэх эрх, үүргийг хүлээн аваагүй нөхцөлд энэхүү баримт бичигт заасны дагуу цахим шилжүүлэг хийх боломжгүй. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгч нь ИЭМЦБ-ийг хэрэглэх замаар тусламж үйлчилгээний тасралтгүй үргэлжлэх хугацаанд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх эрх, үүргийг босоо болон хэвтээ аль аль чиглэлд автоматоор шилжүүлнэ.

3.3. Цахим өвчтний шилжүүлэг хийх бүрд Үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн хураангуй мэдээллийн техникийн шаардлагад заасны дагуу Үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн хураангуй мэдээлэл үүсгэгдэж, шилжүүлж буй лавлагаа тусламж үйлчилгээ үзүүлэх эмч, эмнэлгийн мэргэжилтэнд автоматаар илгээгдэнэ.

3.4. Татгалзах шалтгаан байхгүй тусламж үзүүлэх эрх, үүргийг хүлээн авагч эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгч нь ИЭМЦБ-ийн систем болон ЭЦБ-ийн системийн өгөгдөл солилцооны техникийн шаардлагад заасны дагуу нийцүүлэн лавлагаа тусламж үйлчилгээ үзүүлэх явцад бий болсон Цахим эмнэлгийн баримт бичиг болон эмнэлзүйн лавлагаа мэдээллүүдийг ИЭМЦБ-д систем рүү илгээх үүрэг хүлээнэ.

3.5. Яаралтай тусламж авах, яаралтайгаар хэвтүүлэх шаардлагатай үед энэ заалт хамаарахгүй. ИЭМЦБ-ийн системийн эрх үүрэг шилжүүлэх механизмын тусламжтайгаар мэдээллийн тасалдалгүй байдлыг энэ тохиолдолд хэрэгжүүлэх боломжгүй тул тухайн иргэнийг хариуцсан өрхийн эмч нь эмнэлгийн яаралтай тусламж болон яаралтайгаар хэвтүүлэн эмчлүүлсэн процессын үр дүнд бий болсон эмнэлгийн тусламжийн бүртгэлийг гардан оруулах үүргийг хүлээнэ.

4. Шилжүүлэг

4.1. Энэхүү баримт бичгийн хүрээнд Цахим шилжүүлэг нь дараах үйлдлийг хийнэ. Үүнд:

4.1.1. Шилжүүлэг хийхтэй холбоотой сонголтын хүсэлт гаргах: эрүүл мэндийн байгууллага, үйлчилгээ үзүүлэгчид, тоног төхөөрөмж, тусламж үйлчилгээний талаар цаг тухайд нь шинэчилсэн мэдээллээр хангах

4.1.2. Шилжүүлэгтэй холбоотой хийсэн сонголтыг хүлээн авах: эрүүл мэндийн байгууллага, үйлчилгээ үзүүлэгчид, тоног төхөөрөмж, үйлчилгээг цаг тухайд нь шинэчилсэн мэдээлэлтэй хамт өгөх

4.1.3. Шинээр лавлагаа тусламж авах шилжүүлэг үүсгэх

4.1.4. Хүлээгдэж буй шилжүүлгийн талаар хүлээн авагчид мэдэгдэл дамжуулах

4.1.5. Шилжүүлгийн хариу төлөвийг харуулах

4.1.6. Мэдэгдлийг буцаах эсвэл алдааны хариу үйлдэл, үүнд хариу үйлдэл (response)-ийн үндэслэлийн мэдээллийг оруулах

4.1.7. Шилжүүлгийг өөрчлөх хүсэлт -үүнд цаг товлосон огноо, хугацаа өөрчлөгдөх орох

4.1.8. Шилжүүлэгийг өөрчлөх хүсэлтийн хариу үйлдэл

4.1.9. Шилжүүлгийн хүсэлтийг хүчингүй болгох

5.Тусламж үйлчилгээний нөхцөл байдал

5.1. Амбулаторын тусламж үйлчилгээ

5.1.1. Амбулаторын тусламж үйлчилгээний нөхцөл байдлыг Эрүүл мэндийн тухай болон бусад баримт бичиг, стандартад нийцүүлэн Хавсралт 11-д харууллаа. Амбулаторийн тусламж үйлчилгээний шилжүүлэг нь анхан шатнаас лавлагаа шат руу болон лавлагаа шат (secondary) дотроо хийгдэх шилжүүлгээс тогтоно.

5.1.2. ЭЦБ-ийн системд үүссэн Амбулаторын лавлагаа тусламж үйлчилгээний үр дүн нь төрөлжсөн мэргэжлийн эмчийн Тусламж үйлчилгээний эпизод хэлбэрээр ИЭМЦБ-ийн бүтцэд орж тухайн лавлагаа тусламжийг хүссэн анхдагч шатлалын Тусламж үйлчилгээний эпизодтай шууд холбогдоно. Ингэхдээ шилжүүлэг хийгдсэн анхан шатны тухайн хандалтай (энкаунтер) холбогдоно.

5.1.3. Амбулаторын тусламж үйлчилгээ үзүүлэгч эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд хандаж тусламж үйлчилгээ авах тохиолдол бүрт ЭЦБ-ийн элементүүд ИЭМЦБ-ийн систем рүү илгээгдэхийн зэрэгцээ тухайн харгалзах ЭЦБ-ийн системд хадгалагдана. Өөрөөр хэлбэл ИЭМЦБ-ийн системд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлсэн мэдээлэл, өгөгдлүүд нь эмнэлэгт хандсан тохиолдол бүрээр илгээгдэнэ.

5.1.4. Энэ баримт бичгийн дагуу Амбулаторын ЭЦБ-ийн мэдээллүүд нь ИЭМЦБ-ийн системийн эмчийн портал эсвэл Гуравдагч талын Мэдээллийн системээс ИЭМЦБ-ийн систем рүү илгээгдэнэ.

5.1.5. Амбулаторын лавлагаа тусламж үйлчилгээ авах хүсэлт гаргасан эмч, эмнэлгийн мэргэжилтэн нь үйлчилгээний эрх, үүргээ шилжүүлснээр Үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн хураангуй мэдээлэл автоматаар үүсгэгдэж, шилжүүлж буй эрх, үүрэг бүхий эмч, эмнэлгийн мэргэжилтэнд илгээгдэнэ. Энэ хураангуй мэдээлэлд ИЭМЦБ-ийн эмчийн портал эсвэл үүрэг шилжсэн гуравдагч талын мэдээллийн системээс хандана.

5.1.6. Хавсралт 11 харуулсанаар Амбулаторын лавлагаа тусламж үйлчилгээний шилжүүлэг нь нэг эмч, эмнэлгийн мэргэжилтэнээс нөгөө рүү шууд хийгдэнэ. Ингэхдээ 2 болон түүнээс олон удаагийн амбулаторийн тусламж үйлчилгээ нь хоорондоо бус харин уг шилжүүлгийг эхлүүлсэн анхан шатны *тусламж үйлчилгээний эписод*-той тус тусдаа холбогдоно.

5.1.7. Амбулаторийн давхар шилжүүлэг хийгдэх үед тухайлбал анхдагч шатлалаас лавлагаа шат руу, лавлагаа шатлалаас өөр лавлагаа шатлал руу шилжүүлэг хийгдэх үед *тусламж үйлчилгээний эписод* нь 3 түвшинд байршина. Тухайлбал сүүлийн лавлагаа шатны *тусламж үйлчилгээний эписод* нь эхний лавлагаа шатны *тусламж үйлчилгээний эписод*-той, энэ эписод нь анхан шатны шилжүүлэг хийсэн *тусламж үйлчилгээний эписод*-той тус тус холбогдоно.

5.2. Хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээ

5.2.1. Хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний шилжүүлгийн нөхцөл байдлыг Эрүүл мэндийн тухай болон бусад баримт бичиг, стандартад нийцүүлэн Хавсралт 11-д харуулсан болно. Үүнд нэг байгууллагаас нөгөөд яаралтайгаар хэвтүүлэн эмчлэх шилжүүлэг мөн орсон.

5.2.2. Хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний шилжүүлгээр ЭЦБ бий болох бөгөөд энэ нь төрөлжсөн мэргэжлийн *тусламж үйлчилгээний эписод* хэлбэрээр ИЭМЦБ-д орох ба тухайн шилжүүлгийг хийсэн анхан шатны *тусламж үйлчилгээний эписод*-той холбогдоно. Ялангуяа энэ шилжүүлгийг хийсэн анхан шатны тусламжийн энкаунтертай холбогдоно.

5.2.3. Эмнэлгээс гарах үед ЭЦБ-ийн өгөгдлүүд нь ИЭМЦБ-ийн систем рүү илгээгдэж, хадгалагдана. Ингэхдээ ИЭМЦБ-ийн системд илгээх мэдээлэл нь Тусламж үйлчилгээний эписодод суурилсан байна.

5.2.4. Гуравдагч талын мэдээллийн системээс үүсгэгдэж буй бүх хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний ЭЦБ нь энэхүү баримт бичгийн шаардлага хангасан байна.

5.2.5. Хэвтүүлэн эмчлэх лавлагаа тусламж үйлчилгээ авах хүсэлт гаргасан эмч, эмнэлгийн мэргэжилтэн нь эрх, үүргээ шилжүүлснээр Үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн хураангуй мэдээлэл автоматаар үүсгэгдэж үүрэг хүлээсэн эмч, эмнэлгийн мэргэжилтэнд илгээгдэнэ. Тусламж үйлчилгээ үзүүлэх үүрэг бүхий лавлагаа шатлалын тусламж үйлчилгээ үзүүлэгч эмч, эмнэлгийн мэргэжилтэн эмнэлгийн мэдээллийн системээр дамжуулан үйлчлүүлэгчийн хураангуй мэдээлэлд хандана.

5.2.6. Яаралтай тусламжаар үзүүлсэн Тусламж үйлчилгээний эписод нь тусдаа байх ба түүнийг шилжүүлэг хийсэн анхдагч шатлалын Тусламж үйлчилгээний эписодтой шууд холбоно.

5.2.7. Хэвтүүлэн эмчлэхэд тусламж үйлчилгээний явцад үүссэн хүндрэлийг эмчлэх Тусламж үйлчилгээний эписодыг лавлагаа тусламж үйлчилгээ хүссэн анхдагч шатлалын Тусламж үйлчилгээний эписодтой холбохгүй, харин хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний эписодтой холбогдоно.

БҮЛЭГ VI. ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ХУРААНГУЙ МЭДЭЭЛЛИЙН ТЕХНИКИЙН ШААРДЛАГА

1. Зорилго

1. Энэхүү баримт бичгийн зорилго нь Цахим шилжүүлэг хийх үед эрүүл мэндийн байгууллага хооронд солилцогдох үйлчлүүлэгчийн мэдээллийн талаарх зохицуулгыг бий болгоно.

2. Энэхүү баримт бичиг нь дараах баримт бичгүүдийн хүрээнд хэрэгжинэ. Үүнд:

2.2. ИЭМЦБ-ийн системийн техникийн шаардлага

2.3. ЭЦБ-ийн системийн өгөгдөл солилцооны техникийн шаардлага

2.4. Цахим шилжүүлэгийн техникийн шаардлага

2. Ерөнхий шаардлага

2.1. Үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн хураангуй мэдээлэл нь энэхүү баримт бичгийн Цахим шилжүүлгийн техникийн шаардлагад заасны дагуу шилжинэ.

2.2. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгчид үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн хураангуй мэдээллийг энэхүү баримт бичгийн Цахим шилжүүлгийн техникийн шаардлагад дагуу олон улсын HL7/FHIR, CDA стандартаар бүтэцлэгдсэн, компьютер боловсруулж болох Эмнэлгийн цахим баримт бичиг хэлбэрээр хоорондоо солилцоно.

2.3. Үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн хураангуй мэдээлэл нь энэхүү баримт бичгийн Цахим шилжүүлгийн техникийн шаардлагад заасны дагуу зөвхөн лавлагаа (Хоёрдогч болон гуравдагч) шатлалын эмнэлгүүдэд илгээгдэнэ. Анхан шатны тусламж үзүүлэгчид харьяалах хүрээний үйлчлүүлэгчийн ИЭМЦБ-ийн систем дэхь мэдээлэл рүү нэвтрэх бүрэн эрхтэй байна.

2.4. Шилжүүлгийг хүлээн авч буй төрөлжсөн мэргэжлийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгч нь ИЭМЦБ-ийн систем рүү хандах эрх бүхий Гуравдагч талын ЭЦБ-ийг эмнэлгийн цахим баримт бичгийг үүсгэх, дамжуулахад ашиглаж буй бол Үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн хураангуй мэдээллийг Гуравдагч талын мэдээллийн систем рүү дамжуулна.

2.5. Хүлээн авагч төрөлжсөн мэргэжлийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгч нь эмнэлгийн цахим баримт бичгийг үүсгэх, ИЭМЦБ рүү дамжуулах Гуравдагч талын мэдээллийн системгүй бол ИЭМЦБ-ийн систем болон ЭЦБ-ийн системийн өгөгдөл солилцооны техникийн шаардлагад холбогдох эмнэлгийн цахим баримт бичгийг ИЭМЦБ-ийн эмчийн портал ашиглан бий болгоно. Энэ тохиолдолд Үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн хураангуй мэдээлэл нь хүлээн авагч эмнэлгийн мэргэжилтний ИЭМЦБ-ийн систем дэхь хэрэглэгчийн данс руу шилжинэ. (хандах эрх үүсгэгдэнэ)

3. Мэдээллийн эх сурвалж

Үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн хураангуй мэдээлэлд орох үндсэн өгөгдлүүдийн багцыг хавсралтаар тодорхойлов. (Хавсралт 10).

Хавсралтанд заасан Үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн хураангуй мэдээлэл бий болгох өгөгдлүүд нь зөвхөн ИЭМЦБ-ийн системээс гарна. Эдгээр өгөгдөл тус бүрийн эх сурвалжийг доор дурдсан болно.

Үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн хураангуй мэдээлэлд холбогдох эмнэлгийн цахим баримт бичиг нь цахим шилжүүлгийн үр дүнд ИЭМЦБ-ийн системээс бий болох ба тухайн цаг хугацааны шинэчлэгдсэн бүх өгөгдлүүдийг оруулах нь ИЭМЦБ-ийн функц үйл ажиллагаагаар хангагдана.

Эрүүл мэндийн асуудлууд, оношийн код, үр дүнгүүдийн ангилал нь Өгөгдөл цуглуулах бодлогын дагуу стандарчлагдсан өгөгдлүүд байна. Эдгээр ЭЦБ-ийн бүрэн цахимжсан, дискрет өгөгдлүүд нь ИЭМЦБ-ийн систем дэхь үндсэн өгөгдлийн санд хадгалагдаж, улмаар Үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн хураангуй мэдээлэл нь гаргах боломжийг бүрдүүлнэ.

Өгөгдөл тэмдэглэх- цахим шилжүүлгийн зорилгоос хамаарч ИЭМЦБ-ийн Үндсэн өгөгдлийн сангаас үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн хураангуй мэдээлэл-д орох өгөгдлүүд ялгаатай байж болно. Жишээлбэл вакцин хийлгэх үед урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах шаардлагатай үйлчлүүлэгчийн тодорхой нэг эрүүл мэндийн асуудалтай уялдуулж сонгох. Тодорхой нэг эмнэлзүйн өгөгдлүүдийг тэмдэглэхийн тулд ИЭМЦБ-ийн систем болон ЭЦБ-ийн системийн өгөгдөл солилцооны техникийн шаардлагад заасны дагуу Эмнэлзүйн захиргааны параметруудийг хэрэглэх ба энэ нь тайлагнахад ихээхэн ач холбогдолтой байдаг.

3.1. Анхааруулга

3.1.1. Харшлууд ба үл нийцэл - харшлын нэр ба харгалзах код, харшил ба урвал үүсгэж байгаа бодисын нэр, код зэргийг тодорхойлсон өгөгдлүүд байна.

3.1.2. ИЭМЦБ-ийн стандартын дагуу бүх эрүүл мэндийн асуудлууд эсвэл өвчний онош нь оношийн нэр, кодтой байх бөгөөд ИЭМЦБ-ийн систем нь эдгээр өгөгдлүүдийг аль ч ИЭМЦБ-ийн эсвэл ЭЦБ-ийн тэмдэглэгдсэн харшлын урвал, үл нийцэл эсвэл эмийн харшлын урвалын үр дүнгүүдээс авна. Үр дүн нь үйлчлүүлэгчид бичсэн болон өгсөн эмүүдтэй холбоотойгоор тэмдэглэгдэнэ. ЭЦБ-ийн системд оношилгооны нэр, код нь ӨОУА-10 ангилалын дагуу цуглуулагдана.

3.2. Өнгөрсөн өвчлөлийн түүх

3.2.1. Дархлаажуулалт- үйлчлүүлэгчид хийсэн вакцины мэдээлэл ИЭМЦБ-ийн Цахим жорын үйлчилгээг хэрэглэн үүсэж ИЭМЦБ-ийн цахим жорын *эмнэлгийн цахим баримт бичиг*-ийн хэсэгт байршиж, *үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн хураангуй мэдээлэл* үүсгэхэд хэрэглэгдэнэ.

3.2.2. Дархлаажуулалтийн мэдээлэл нь ИЭМЦБ-ийн системээс харгалзах тусламж үйлчилгээний эпизод буюу урьдчилан сэргийлэх тусламж

үйлчилгээний эписодоос дуудагдана. Дархлаажуулалтын зорилгыг тусламж үйлчилгээний эписодтой холбоотой “эрүүл мэндийн байдал”-ын нэр, кодоор тэмдэглэх бөгөөд энэ нь тухай вакцинаар сэргийлэгдэх өвчний нэр, код байна. “Эрүүл мэндийн байдал”-ыг урьдчилан сэргийлэх гэж тэмдэглэгдсэн үед тусламж үйлчилгээний эписод нь дархлаажуулалтын эхний тунг хийх үед эхлэж дархлаажуулалтын сүүлийн тун хийх үед хаагдана.

3.2.3. *Өмнөх эрүүл мэндийн асуудлуудын жагсаалт* - тусламж үйлчилгээний эписод-ийн төлөв нь ИЭМЦБ-ийн системд эмнэлзүйн захиргааны параметр (clinical administrative parameter)-үүдийг ашиглан тэмдэглэсэн, тухайлбал шийдвэрлэгдсэн, хаасан, идэвхгүй гэх мэт, эрүүл мэндийн асуудлын жагсаалт байна. Жагсаалт нь зөвхөн хамгийн дээд түвшний буюу анхдагч шатлалд байршсан (nested) тусламж үйлчилгээний эписодуудаар үүсгэгдэнэ. Шийдвэрлэсэн онош нь төрөлжсөн мэргэжлийн эмчийн эсвэл хэрвээ өрхийн эмч боломжтой бол аль алиных нь хамгийн доод түвшинд тодорхойлсон эрүүл мэндийн асуудлын нэр байна. Энэ оношийн нэр, кодыг зөвхөн хамгийн сүүлийн тусламж үйлчилгээний хандалтаар авна.

3.2.4. Мэс заслын түүх (Хийлгэсэн мэс заслын жагсаалт) – ИЭМЦБ-ийн системд мэс ажилбарууд нь YОУА-9 ангилалын дагуу ЭЦБ-ийн харгалзах утгыг тодорхойлсон нэр, кодтой байна. Мэс заслын нэр, кодыг Эрүүл мэндийн үндэсний лавлагаа мэдээний сангийн YОУА-9 ашиглаж сонгон *үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн хураангуй мэдээлэл*-д оруулна.

3.3. Одоогийн өвчлөлийн түүх

3.3.1. Одоогийн өвчлөлийн оношийн жагсаалт- “Эрүүл мэндийн байдал”-тай холбоотой анхан шатны түвшинд үүссэн, нээлттэй гэж тэмдэглэгдсэн тусламж үйлчилгээний эписодуудын нэр, код бүхий жагсаалт байна. “Эрүүл мэндийн байдал”-д диспансерын хяналтын давтан үзлэг эсвэл байнгын, ноцтой гаж нөлөө бүхий эмийн эмчилгээний үеийн архаг эсвэл дахих байдлууд хамаарна.

3.3.2. Энэхүү баримт бичгийн ИЭМЦБ-ийн системийн техникийн шаардлагад заасны дагуу одоогийн эрүүл мэндийн асуудлууд нь *үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн хураангуй мэдээлэл*-д үргэлжилж буй төрөлжсөн мэргэжлийн байршуулсан *тусламж үйлчилгээний эписод*-ийн нэр, кодтой хамт илгээгдэх ба ингэхдээ амбулаторийн болон хэвтэн эмчлүүлэх *тусламж үйлчилгээний эписод*-уудын аль аль нь орж өөрсдийн төлөвөөс хамаарч нээлттэй гэж тэмдэглэгдэнэ.

3.3.3. Эмнэлгийн хэрэгсэл ба суулгацууд- Үйлчлүүлэгчийн хэрэглэж буй эрүүл мэндийн өвөрмөц байдалд дэмжлэг үзүүлэх хэрэгслүүд орно. Эдгээр хэрэгслүүдийг мэс заслын явцад үйлчлүүлэгчийн биед байршуулах ба ИЭМЦБ-ийн өгөгдлийн санд Өөртөө үзүүлэх тусламж гэж ангилагдаагүй байна. ИЭМЦБ-ийн системд эдгээр хэрэгслүүдтэй холбоотой мэдээллийг оруулахдаа мэс заслын ажилбарт хэрэглэгдэх хэрэгслүүдийн 3.2.4 заалтын дагуу ангилалыг тус тус ашиглана.

- 3.3.4. *Ойрын хугацаанд хийлгэсэн мэс заслууд* – 3.2.4 зүйлд заасны дагуу гаргасан мэс заслын жагсаалт;

4.4. Эмийн мэдээлэл

- 4.5.1. Одоо хэрэглэж байгаа эмийн мэдээлэл- Эмчийн бичсэн жор, түүний дагуу олгосон, хэрэглэсэн эмийн мэдээлэл нь харгалзах ЭМЦ-ийн систем эсвэл ИЭМЦБ-д хадгалагдах ба ИЭМЦБ-ийн систем рүү илгээгдэхдээ өөртөө үзүүлэх тусламж (prescribed self-care)-ийн өгөгдлийн загварыг хэрэгжүүлж ашиглана.

4.5. Бусад мэдээлэлүүд

- 4.5.1. Анхан шатны *тусламж үйлчилгээний эписод*-оос жирэмсний талаар мэдээллийг харгалзах нэр, кодийн хүрээнд татан гаргаж болох тул энэ бүлэгт хамаарахгүй. Энэ бүлэгт заасны дагуу ИЭМЦБ-ийн өгөгдөл цуглуулах бодлогыг хэрэгжүүлэх явцад ИЭМЦБ-д цуглуулагдсан өгөгдлөөс боловсруулан гаргаж болох бусад мэдээллүүд (ажиглалт, үр дүнгүүд) орно. Бусад мэдээллүүд нь ИЭМЦБ-д Эмнэлгийн цахим баримт бичиг хэлбэрээр цуглуулагдах бөгөөд ИЭМЦБ-ийн систем болон ЭЦБ-ийн системийн өгөгдөл солилцооны техникийн шаардлагад заасан өгөгдөл цуглуулах бодлогын дагуу Үйлчлүүлэгчийн хураангуй мэдээлэлд орох өгөгдөл нь дискрет өгөгдөл байна.

БҮЛЭГ VII. ЦАХИМ ЖОР

1. Зорилго, зорилтууд

Цахим жорын мэдээллийг Эрүүл мэндийн мэдээлэл солилцох платформоор дамжуулан Иргэний эрүүл мэндийн цахим бүртгэлийн систем, Эрүүл мэндийн даатгалын мэдээллийн систем болон эмийн сан, иргэний хооронд мэдээллийг солилцох, ашиглах боломжийг бүрдүүлэх зорилготой. Дараах зорилтуудыг хэрэгжүүлнэ. Үүнд:

- 1.1. Эмнэлгийн цахим бүртгэлийн систем дэх Цахим жорын системийн бүтэц, үндсэн өгөгдлүүдийг стандарчлах
- 1.2. Цахим жор бичих, цахимаар жор олгох үйл ажиллагааг стандарчлах
- 1.3. Эмнэлгийн цахим бүртгэлийн систем дэх Цахим жорын системд тавигдах шаардлагыг тодорхойлох
- 1.4. Үндэсний хэмжээнд эмийн бүртгэлийн нэгдсэн мэдээний сан, ангиалыг ашиглах
- 1.5. Эмнэлгийн цахим бүртгэлийн систем дэх Цахим жорын системд үүссэн жорын мэдээллийг Эрүүл мэндийн салбарын мэдээлэл солилцох платформоор дамжуулан Иргэний эрүүл мэндийн цахим бүртгэлийн систем, Эрүүл мэндийн даатгалын мэдээллийн систем болон эмийн сан, иргэний хооронд мэдээллийг солилцох, ашиглах боломжийг бүрдүүлэх зэрэг болно.

2. Ерөнхий зүйл

2.1 Цахим хэлбэрээр эмийн жор бичих, эм олгоход “Эмийн жорын маягт, жор бичилт” MNS 5376: 2016 стандартыг бүхэлд нь баримтлах ба цахим жор цаасан жорын нэгэн адил үйлчилнэ.

3.Цахим жорын бүтэц, үндсэн өгөгдлүүд

3.1. Цахим жорын бүтэц нь “Эмийн жорын маягт, жор бичилт” MNS 5376:2016 стандартын 5.3, 5.4-д заасан үндсэн өгөгдлүүдийг бүрэн агуулсан байх ба энэ хязгаарлалт болохгүй.

3.2 Цахим жор нь дараах бүтэцтэй байна.

- 3.2.1 Үйлчлүүлэгчийн ялган таних мэдээлэл
- 3.2.2 Жорын мэдээлэл
- 3.2.3 Жороор олгох эмийн мэдээлэл
- 3.2.4 Жор бичигчийн/эмчийн ялган таних мэдээлэл
- 3.2.5 Жор бичигчийн/эмчийн харьяалах эрүүл мэндийн байгууллагын ялган таних мэдээлэл
- 3.2.6 Жороор олгосон эмийн мэдээлэл
- 3.2.7 Жор баригчийн ялган таних мэдээлэл
- 3.2.8 Жор баригчийн харьяалах эмийн сангийн ялган таних мэдээлэл

3.3. Цахим жорын бүтэц, үндсэн өгөгдлүүд, түүнд тавигдах техникийн шаардлагыг Хавсралт 12-д зааснаар тодорхойлно.

4. Цахим хэлбэрээр жор бичих алхамууд

4.1 Жор бичигч системд өөрийн ялган таних нууц үгээр нэвтрэх

4.2 Жор бичигч систем үйлчлүүлэгчийг регистрийн дугаар, бүртгэлийн дугаар, овог, нэр, төрсөн он сар өдрөөр ялган таних

4.3 Шинээр жор үүсгэх, бичих

4.3.1 Эмийн нэр, тун хэмжээ хэлбэрийг системээс хайж, сонгох эсвэл гараар оруулах

4.3.2 Эмийн хэрэглэх арга, эмчилгээний хугацааг сонгох эсвэл гараар оруулах

4.3.3 Үйлчлүүлэгчид эмийг хэрэглэх заавар, зөвлөмжийг Монгол хэл дээр ойлгомжтойгоор чөлөөт текстээр бичиж оруулах

4.4 Шинээр жор үүсгэсэн жорыг баталгаажуулах, гарын үсэг зурах

4.5 Жорыг үйлчлүүлэгчийн сонгосон Эмийн сан, Иргэний эрүүл мэндийн цахим бүртгэлийн систем болон бусад холбогдох журмаар зохицуулсан мэдээллийн систем рүү илгээх

5. Цахим жороор эм олгох алхамууд

5.1 Жор баригч нь эмийн сангийн цахим бүртгэлийн системд өөрийн ялган таних нууц үгээр нэвтрэх

5.2 Жор баригч нь үйлчлүүлэгчийн Регистрын дугаарыг системд оруулж ялган таних

5.3 Жор баригч нь системээс илгээсэн жорын жагсаалтыг хайж олох

5.3.1 Эмийн нэр, тун хэмжээ хэлбэрийг системээс хайж, сонгох эсвэл гараар оруулах

5.3.2 Эмийн хэрэглэх арга, эмчилгээний хугацааг сонгох эсвэл гараар олгох

5.3.3 Үйлчлүүлэгчид эмийг хэрэглэх заавар, зөвлөмжийг Монгол хэл дээр ойлгомжтойгоор чөлөөт текстээр бичиж оруулах

5.4 Жороор олгосон эмийг баталгаажуулах, гарын үсэг зурах

5.5 Жороор олгосон эмийн жагсаалтыг Иргэний эрүүл мэндийн цахим бүртгэлийн систем болон бусад холбогдох журмаар зохицуулсан мэдээллийн систем рүү илгээх

6. Эмнэлгийн цахим бүртгэлийн системийн цахим жорын системд тавигдах шаардлага

6.1 Эмнэлгийн цахим бүртгэлийн систем нь эмийн цахим жорын модультай /Цаашид цахим жорын систем гэнэ/ байна.

6.2 Эмнэлгийн цахим бүртгэлийн систем дэх цахим жорын систем нь дараах үйлдлийг заавал гүйцэтгэдэг байх ба энэ нь хязгаарлалт болохгүй. Үүнд:

6.2.1. Эмч шинэ жорны идэвхтэй бодис болон тунгийн маягтыг идэвхжүүлэхэд уг хүсэлтийн дагуу илгээсэн жор дахь идэвхитэй бүх бодисын жагсаалт, тэдгээрийн харилцан үйлчлэлийн мэдээлэл болон холбоотой жорын жагсаалтыг харуулдаг байна.

- 6.2.2. Эмч зөвхөн үйлчлүүлэгчийн давтагдахгүй дугаарыг оруулахад уг өвчтөнд өмнө нь бичигдсэн жоруудын мэдээллийг харуулдаг байна. Энэ нь шинэ жор үүсгэхгүйгээр эмийн харилцан үйлчлэлийг байгаа эмүүдийн хүрээнд шалгахад ашиглагдана.
- 6.2.3. Системд идэвхитэй бодисын нэр, код буюу АТС код зэргийг ЭММСП-оор дамжуулан эмийн бүртгэлийн сан (Licemed) –ийг ашиглана.
- 6.2.4. Үйлчлүүлэгч нь ЭМД-тай тохиолдолд жор бичиж буй эм даатгалын хөнгөлөлтөнд хамаарах эсэх талаар мэдээллийг өгнө. Энэ мэдээллийг эмнэлгийн цахим бүртгэлийн систем нь ЭММСП-оор дамжуулан Эрүүл мэндийн даатгалын сангийн лавлах сервисээр авна.
- 6.2.5. Эмч бичсэн жороо цуцлах, хүчингүй болгох боломжтой байна.
- 6.2.6. Эмч урьд нь бичигдсэн жорын жагсаалтыг ЭММСП-оор дамжуулан ИЭМЦБ-ийн сан болон ЭМД-ын сангаас харах боломжтой байна. Жагсаалт нь жорын дугаар, жор бичсэн болон дуусах огноо, эмчийн нэр, эмчийн мэргэжил зэрэг мэдээллийг агуулсан байна.
- 6.2.7. Эмч шаардлагатай тохиолдолд жорын жагсаалтаас жорыг нээж харах боломжтой байна.
- 6.3. Цахим жорын систем нь эмнэлгийн цахим бүртгэлийн системийн үйлчлүүлэгчийн ялган таних бүртгэлийн мэдээлэлтэй холбогдсон байна.
- 6.4. Цахим жорын систем нь эмийн хайлтын системтэй байна.
- 6.5. Хэрэглэгчийн байнга бичдэг жорын жагсаалтуудыг харуулдаг байх ба дахин жор бичих боломжтой байна.
- 6.6. Цахим жорын систем нь эмийн тайлан гаргах модултай байна.
- 6.7. Цахим жорын систем нь barcode унших чадвартай байна.
- 6.8. Цахим жорын систем нь нэг болон хамтарсан цахим гарын үсгийг дэмжих боломжтой байна.
- 6.9. Цахим жорын систем нь жорын мэдээллийг үйлчлүүлэгчийн сонгосон эмийн сан руу илгээх чадамжтай байна.
- 6.10. Цахим жорын систем нь энэхүү журмын хавсралт 12 –д заасан үндсэн өгөгдлийн бүтэц, түүнд тавигдсан шаардлага хангасан байна.

7. Иргэний эрүүл мэндийн цахим бүртгэлийн системийн үйлчилгээ

- 7.1 ИЭМЦБ-ийн сан нь Эмнэлгийн цахим бүртгэлийн системээс цахим жорын мэдээллийг хүлээн авч цахим жорын хэсэгт хадгална.
- 7.2 ИЭМЦБ-ийн сан нь дараах үйлчилгээг үзүүлнэ. Үүнд:
 - 7.2.1 Санд хадгалагдаж буй жорын жагсаалт, тэдгээрийн төлөв байдал
 - 7.2.2 Цуцлагдсан жорын мэдээлэл
 - 7.2.3 Хөнгөлөлтэй олгогдсон жорын мэдээлэл
 - 7.2.4 Эмийн олон улсын ангилал (идэвхитэй бодисын нэр, код буюу АТС код) лавлагаа мэдээлэлээр хангах

7.3 ИЭМЦБ-ийн санд хадгалагдсан цахим жорын мэдээллийг эрүүл мэндийн өгөгдөл солилцооны платформоор ЭМД-ын хөнгөлөлттэй эмийн цахим жорын системтэй солилцоно.

7.4 Иргэн өөрийн цахим жорын мэдээллийг ИЭМЦБ-ийн үйлчлүүлэгчийн порталыг ашиглан харах, хянах боломжтой.

8. Эмийн сангийн цахим бүртгэлийн систем

8.1 Иргэний эрүүл мэндийн цахим бүртгэлийн санд байгаа хадгалагдсан цахим жорын мэдээлэл нь эрүүл мэндийн өгөгдөл солилцооны платформ(HIEP)-оор дамжуулан цахим мэдээллийн систем бүхий эмийн сангийн системтэй солилцоно.

8.2 Цахим мэдээллийн систем байхгүй эмийн сан нь ИЭМЦБ-ийн эмчийн порталын цахим жорын интерфэйсийг ашиглан жорыг харах, худалдсан эмийн мэдээллийг оруулах боломжтой байна.

8.3 Эмийн сан нь жорын дагуу эмийн олголтыг баталгаажуулж, мэдээллийг ИЭМЦБ-ийн сан руу дамжуулна.

8.4 ИЭМЦБ-ийн санд ирсэн эмийн баталгаажсан олголтыг ЭМД-ын сан руу дамжуулна.

8.5 ИЭМЦБ-ийн санд ирсэн эмийн баталгаажсан олголтыг идэвхигүй төлөвт шилжүүлж цаашид эмийн сангаас олгох боломжгүй болно.

9. Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын үүрэг

9.1 Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар нь өөрийн мэдээний сангаас дараах мэдээллүүдийг хамгийн сүүлийн хувилбараар ЭММСП-д вэб сервисээр гаргаж өгдөг байна. Үүнд:

9.1.1 Хөнгөлөлттэй эмийн жагсаалт

9.1.2 Үйлчлүүлэгчийн даатгалтай эсэх лавлагаа

9.1.3 Жороор олгогдсон хөнгөлөлттэй эмийн жагсаалт

9.1.4 Үйлчлүүлэгчид олгож болох хөнгөлөлтийн хувь, мөнгөн дүн

9.1.5 Баталгаажсан олголтыг хүлээн авах

10. Эрүүл мэндийн хөгжлийн төвийн үүрэг


10.1 Эрүүл мэндийн хөгжлийн төв нь улсын бүртгэлд бүртгэгдсэн эмийн мэдээний сангаас дараах мэдээллүүдийг хамгийн сүүлийн хувилбараар ЭММСП-д вэб сервисээр гаргаж өгдөг байна. Үүнд:

10.1.1 Монгол улсад бүртгэгдсэн эмийн жагсаалт, олон улсын АТС ангилал, кодчлол


10.1.2 Эмийн сангийн мэдээлэл

10.1.3 Эмийн харилцан үйлчлэлцэл, гаж нөлөөний мэдээлэл

ИЭМЦБ-ийн системийн техникийн архитектурын зураглал



Харилцан үйлчлэлцэл бүхий тусламж үйлчилгээний эписодууд



**АМБУЛАТОРЫН ЭМЧИЙН ҮЗЛЭГИЙН ТЭМДЭГЛЭЛИЙН
ӨГӨГДЛИЙН БҮТЭЦ, ТҮҮНД ТАВИГДАХ ТЕХНИКИЙН ШААРДЛАГА**

**Хүснэгт 1. Амбулаторын эмчийн үзлэгийн тэмдэглэлийн
өгөгдлийн бүтцийн нэгдсэн товчоон**

Баримт бичгийн бүрэлдхүүн хэсэг	Өгөгдлийн бүрэлдэхүүн хэсэг	Opt	Өгөгдлийн төрөл	Өгөгдлийн элементийн давтагдах шинж чанар
1	Үйлчлүүлэгчийн талаарх мэдээлэл	Ш	Техт	Тийм
2	Лавлагаа тусламж авахаар илгээсэн эмч, эмнэлгийн мэргэжилтний тухай мэдээлэл	С	Техт	Тийм
3	Амбулаторийн эмчийн үзлэгийн эписодын мэдээлэл	Ш	Техт	Тийм
4	Үйлчлүүлэгчийн одоогийн өвчний түүх	Ш	Техт	Тийм
5	Үйлчлүүлэгчийн өмнөх өвчлөлийн түүх	С	Техт	Тийм
6	Хорт зуршил	С	Техт	Тийм
7	Гэр бүлийн гишүүд, ойр дотны хүмүүсийн өвчлөлийн талаарх мэдээлэл	С	Техт	Тийм
8	Үйлчлүүлэгчийн хэрэглэж байгаа эмийн талаарх мэдээлэл	С	Техт	Тийм
9	Эмийн харшил, гаж нөлөөний мэдээлэл	Ш	Техт	Тийм
10	Үйлчлүүлэгч биед байгаа суулгац, хиймэл эрхтэний талаарх мэдээлэл	С	Техт	Тийм
11	Амин үзүүлэлт	С	Техт	Тийм
12	Хийгдэх шинжилгээ, оношилгоо, эмчилгээний төлөвлөгөө	С	Техт	Тийм
13	Оношийн мэдээлэл	Ш	Техт	Тийм
14	Мэс засал, мэс ажилбарын талаарх мэдээлэл	Ш	Техт	Тийм
15	Дүрс оношилгооны үр дүнгийн мэдээлэл	Ш	Техт	Тийм
16	Лабораторийн шинжилгээний үр дүнгийн мэдээлэл	Ш	Техт	Тийм
17	Үйлчлүүлэгчид өгсөн зөвлөгөө	Ш	Техт	Тийм
18	Цахим жор	Ш	Техт	

19	Тухайн эмнэлгийн цахим маягтыг хөтлөсөн эрх бүхий эмнэлгийн мэргэжилтний мэдээлэл	Ш	Техт	
20	Эрүүл мэндийн байгууллага	Ш	Техт	
21	Хавсаргасан эмнэлгийн баримт бичгүүд	С	Хавсралт	Тийм
Тэмдэглэгээ: Утга авах нөхцөл= Тухайн өгөгдлийн элементийг зайлшгүй байх эсэх эсвэл байхгүй байж болохыг эсэхийг тодорхойлно. Ш= Шаардлагатай С= Сонголтоор				

Хүснэгт 2. Амбулаторын эмчийн үзлэгийн тэмдэглэлийн өгөгдлийн бүтцийн элементүүд

		Бүрэлдэхүүн хэсэг	Card.	Өгөгдлийн төрөл	Тодорхойлолт
1	Үйлчлүүлэгчийн талаарх мэдээлэл				
1.1	Patient ID		0..*	Ялган танигч	Үйлчлүүлэгчийн ялган танигч
	1.1.1	Value	0..1	Техт	Үйлчлүүлэгчийн ялган таних дугаар
	1.1.2	Assigner	0..1	Техт	Үйлчлүүлэгчийн ялган таних дугаар олгосон байгууллага
1.2	Registration ID		1..1	Техт	Үйлчлүүлэгчийн бүртгэлийн дугаар
1.3	Name		0..*	Техт	Үйлчлүүлэгчийн нэр
	1.3.1	Family	1..1	Техт	Эцэг/эхийн нэр
	1.3.2	Given	1..1	Техт	Өөрийн нэр
1.3	Birthdate		1..1	Огноо	Үйлчлүүлэгчийн төрсөн он сар өдөр
1.4	Gender		1..1	Кодолсон техт	Үйлчлүүлэгчийн хүйс
1.5	Address		0..*	Хаяг	Үйлчлүүлэгчийн хаягийн мэдээлэл
	1.5.1	Address line	1..1	Техт	Хаягийн мөр
	1.5.2	Aimag/city	1..1	Кодолсон техт	Аймаг, хот
	1.5.3	Soum/disrict	1..1	Кодолсон техт	Сум,дүүрэг
	1.5.4	Bag/khoroo	1..1	Кодолсон техт	Хороо,баг
1.6	Telecom		0..*	Contact point	Үйлчлүүлэгчийн цахим хаягийн мэдээлэл
	1.6.1	Type	0..1	Кодолсон техт	Цахим харилцаа холбооны хэрэгслийн төрөл
	1.6.2	Value	0..1	Техт	Цахим харилцаа холбооны дугаар, хаяг
	1.6.3	Use	0..1	Кодолсон техт	Цахим харилцаа холбооны хэрэглээ
1.7	Contact person		0..*	Техт	Яаралтай үед холбоо барих хүний мэдээлэл
2	Лавлагаа шатны тусламж үйлчилгээ авахаар илгээсэн эрх бүхий эмч, эмнэлгийн мэргэжилтэн				
2.1	Referrer ID		0..1	Ялган танигч	Эмч, эмнэлгийн мэргэжилтний ялган танигч
	2.1.1	Value	1..1	Техт	Эмч, эмнэлгийн мэргэжилтний ялган таних дугаар
	2.1.2	Assigner	1..1	Техт	Эмч, эмнэлгийн мэргэжилтний ялган таних дугаар олгосон байгууллага
2.2	Name		0..1	Хүний нэр	Эмч, эмнэлгийн мэргэжилтний нэр
	2.2.1	Family	1..1	Техт	Эцэг/эхийн нэр
	2.2.2	Given	1..1	Техт	Өөрийн нэр
2.3	Role of Referrer		0..1	Техт	Илгээсэн эмч

				1-Өрхийн эмч, 2-бусад
2.4	Health organization	0..1	Төхт	Лавлагаа шатны тусламж үйлчилгээ авахаар илгээсэн эрх бүхий эмч, эмнэлгийн мэргэжилтэн харьяалагдах эрүүл мэндийн байгууллага
3	Амбулаторын эмчийн үзлэгийн энкантурын мэдээлэл			
3.1	Date and time of appointment	1..1	Кодолсон төхт	Амбулаториор үзүүлэхээр товлосон он сар өдөр, цаг минут
3.2	Date and time of contact	1..1	Кодолсон төхт	Амбулаториор үзүүлсэн он сар өдөр, цаг минут
3.3	Outpatient department	1..1	Кодолсон төхт	Амбулаторын үзлэгийн кабинетын төрөл
3.4	Location	1..1	Төхт	Амбулаторын үзлэгийн кабинетын байршил
3.5	Type of consultation	1..1	Кодолсон төхт	1-өвчний учир, 2- урьдчилан сэргийлэх, 3-архаг өвчний хяналт, гэрийн үзлэг, 5-дуудлагаар, 6-яаралтай
3.6	Type of visit	1..1	Кодолсон төхт	1-өвчний учир анх, 2- өвчний учир давтан
3.6	Outcome	1..1	Кодолсон төхт	Амбулаторийн үзлэгийн үр дүнгийн ангилал 1- сүүлийн үзлэг, 2- давтан үзлэгийн цаг товлосон, 3- дараагийн шатлалд шилжүүлсэн, 4- эмнэлэгт хэвтүүлэх төлөвлөсөн , 5- бусад
4	Chief Compliant and Reason for Visit	0..*		Үйлчлүүлэгчийн одоогийн өвчний түүх
4.1	Reason for visit	0..1	Төхт	Эмнэлэгт хандах болсон шалтгаан
4.2	Compliant	0..1	Төхт	Үйлчлүүлэгчийн одоогийн зовиур
4.3	History of present illness	0..1	Төхт	Үйлчлүүлэгчийн одоогийн өвчний түүх
5	Past medical history	0..*		Үйлчлүүлэгчийн өмнөх өвчний түүх
5.1	Communicable diseases	0..*	Төхт	Өмнө нь өвдөж байсан хурц халдварт өвчин
5.2	Noncommunicable diseases	0..*	Төхт	Өмнө нь өвдөж байсан халдварт бус өвчин
5.3	Genetic diseases	0..*	Төхт	Удамшлийн өвчин
6	Social history			Үйлчлүүлэгчийн хорт зуршил хэрэглэдэг эсэх талаарх мэдээлэл
6.1	Smoking history	0..1	Төхт	Үйлчлүүлэгчийн тамхи хэрэглэдэг эсэх
6.2	Alcohol history	0..1	Төхт	Үйлчлүүлэгчийн архи хэрэглэдэг эсэх
7	Family history			Үйлчлүүлэгчийн гэр бүлийн гишүүд, ойр дотны хүмүүсийн өвчлөлийн талаарх мэдээлэл
7.1	Family history	0..*		This is a Family history record entry. There may be 0 to many record entry/entries under a section. Each record entry is made up of a number of elements or data items.

				Энэ бүтэц нь хэдэн ч элементүүд оруулах боломжтой байх
7.2	Family history	0..1	Техт	Үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн байдал, эсвэл үйлчлүүлэгчид үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд шийдвэрлэх ач холбогдол бүхий сүрьеэ, хорт хавдар зэрэг өвчнөөр гэр бүлийн гишүүд, ойр дотны хүмүүс өвдөж байсан өгүүлэмж
8	Medical devices	0..*	Суулгац талаарх мэдээлэл	
8.1	Implant	0..1	Техт	Үйлчлүүлэгчийн биед ямар нэгэн суулгац, хиймэл эрхтэн байгаа эсэх талаарх мэдээлэл
9	Medication history	0..*	Үйлчлүүлэгчийн хэрэглэж байгаа эмийн талаарх мэдээлэл	
9.1	Drug international name	0..1	Техт	Эмийн олон улсын нэршил
9.2	Strength	0..1	Техт	Эмийн хэрэглэсэн тун хэмжээ
9.3	Dose form	0..1	Техт	Эмийн хэлбэр
9.4	Frequency of intake	0..1	Техт	Эмийн 1 удаагийн болон хоногийн давтамж
9.5	Duration of intake	0..1	Техт	Эмийн уух хугацаа
10	Allergy and adverse reaction	0..*	Эмийн харшил, гаж нөлөөний мэдээлэл	
10.1	Causative agent	1..1	Кодолсон текст	Харшил үүсгэгч эмийн бодис, хоол хүнс болон бусад хүчин зүйлүүд хамаарах бөгөөд харшил үүсгэгч тодорхойгүй байж болно.
10.2	Description	0..1	Техт	Харшил болон хариу урвалд үзүүлсэн клиник шинж тэмдэгүүд
10.3	Severity	0..1	Техт	Хариу урвалын илрэлийн хүнд, хөнгөний зэрэг
10.4	Type of reaction	0..1	Кодолсон текст	The type of reaction experienced by the patient (allergic, intolerance) Coded text Allergy, Intolerance, Not known
10.5	Date of experienced	0..1	Техт	Харшил анх илэрсэн он сар өдөр
11	Vital sign	0..*	Амин үзүүлэлт	
11.2	Blood pressure	0..1	Бодит тоо	Цусны дээд, доод даралтын хэмжээ
11.3	Pulse	0..1	Бодит тоо	Судасны цохилтын тоо
11.4	Биеийн жин	0..1	Бодит тоо	Биеийн жин
11.5	Биеийн өндөр/урт	0..1	Бодит тоо	Биеийн өндөр-насанд хүрэгчид хүүхдэд-биеийн урт
11.6	BMI	0..1	Бодит тоо	Биеийн жингийн индекс
12	Treatment plan		Үйлчлүүлэгчийн эмчилгээ, оношилгооны төлөвлөгөө	

12.1	Treatment plan	0..*	Төхт	Хийгдэх шаардлагатай оношилгоо, шинжилгээний жагсаалт
13	Diagnosis	0..*	Оношийн талаарх мэдээлэл	
	Type	0..1	Кодолсон төхт	1-үндсэн онош, 2-хавсарсан онош, 3-хүндрэлийн онош
	Name	0..1	Төхт	Оношийн нэр
	Code	0..1	Төхт	Оношийн код ӨОУА-10 ангиллын дагуу
14	Хийгдсэн мэс засал, мэс ажилбар			
14.1	Code	0..1		
	9.1.1 Name	1..1	Төхт	Мэс засал, мэс ажилбарын нэр
	9.1.2 Code	1..1	Төхт	ӨОУА-9-СМ код
14.2	Anesthesia type	0..1	Төхт	1-ерөнхий, 2-нугасны, 3-судсаар
14.4	Date of surgery	1..1	Он сар өдөр	Мэс засал, мэс ажилбар хийсэн он сар өдөр
15	Дүрс оношилгооны шинжилгээний үр дүн			
15.1	Patient ID	1..1	Төхт	Үйлчлүүлэгчийн ялган таних дугаар
15.2	Record ID	1..1	Төхт	Үйлчлүүлэгчийн өвчний түүхийн дугаар
15.3	Patient name	1..1	Төхт	Үйлчлүүлэгчийн нэр
15.4	Diag Procedure Name	1..1	Төхт	Дүрс оношилгооны шинжилгээний төрөл
15.5	Diag Procedure Test result	0..1	Төхт	Дүрс оношилгооны шинжилгээний үр дүн
15.6	Date of performed	1..1	Он сар өдөр	Дүрс оношилгооны шинжилгээ хийсэн он сар өдөр
15.7	Interpreter	0..1	Төхт	Дүрс оношилгооны шинжилгээний дүгнэлт бичсэн эмч, эмнэлгийн мэргэжилтний нэр
16	Лабораторын шинжилгээний үр дүнгүүд			
16.1	Category	0..1	Кодолсон төхт	1-гематологи, 2-биохими, 3-микробиологи/вирусологи , 4-анатомийн патологи, 5-бусад/LOINC code
16.2	Patient ID	1..1	Төхт	Үйлчлүүлэгчийн ялган таних дугаар
16.3	Record ID	1..1	Төхт	Үйлчлүүлэгчийн өвчний түүхийн дугаар
16.4	Patient	1..1	Төхт	Үйлчлүүлэгчийн нэр
16.5	Lab report test name	1..1	Төхт	LOINC code
16.6	Lab report test name ID	1..1	Төхт	LOINC code
16.7	Lab test result numeric	1..1	Төхт	Лабораторын шинжилгээний тоогоор илэрхийлэгдэх үр дүн
16.8	Unit	1..1	Төхт	Хэмжих нэгж
16.9	Lab test result text	1..1	Төхт	Лабораторын шинжилгээний төхтөөр илэрхийлэгдэх үр дүн. Тухайлбал, эерэг, сөрөг, эсвэл (+, ++, +++)

16.10	Abnormal result indicator		1..1	Төхт	Лабораторийн шинжилгээний тоон үр дүн лавлагаа стандарт хэмжээнээс дээш буюу түүнээс доогуур илэрхийлсэн тэмдэгт
	11.10.1	Low	1..1	Төхт	Н-лавлагаа стандарт дээд хэмжээнээс их
	11.10.2	High	1..1	Төхт	Л- лавлагаа стандарт доод хэмжээнээс бага
16.11	Reference range		0..1	Төхт	Лавлагаа хэмжээний дээд болон доод хязгаар
	11.10.1	Low	1..1	Төхт	Доод хязгаар
	11.10.2	High	1..1	Төхт	Дээд хязгаар
16.12	Issued date		1..1	Төхт	Шинжилгээний хариуг баталгаажуулсан он сар өдөр
16.13	Performer		1..1	Төхт	Лабораторын шинжилгээний хариуг баталгаажуулсан лаборант, лабораторын эмч
17	Эмийн жор				
17.1	Drug international or trade name		1..1	Төхт	Эмийн олон улсын нэршил эсвэл худалдааны нэршилийн ангилал
17.2	Strength		0..1	Төхт	Эмийн тун хэмжээ
	Strength Value		1..1	Төхт	Тун хэмжээний утга
	Strength Unit		1..1	Төхт	Хэмжих нэгж
17.3	Pharmaceutical dose form		0..1	Төхт	Эмийн хэлбэр
	Code from coding list		1..1	Төхт	Эмийн хэлбэрийн ангилалын код
	Label of code		1..1	Төхт	Харгалзах эмийн хэлбэрийн ангилал
17.4	Route of administration		1..1	Төхт	Эмийн хэрэглэх арга
	Code from Route of Administration code list		1..1	Төхт	Эмийн хэрэглэх аргын ангилалын код
	Label of code of Administration code list		1..1	Төхт	Харгалзах эмийн хэрэглэх аргын ангилал
17.5	Frequency of intakes		0..1	Coded text	Эмийн 1 удаагийн болон хоногийн давтамж
17.5.1	Strength value		1..1	Төхт	Эмийн 1 удаагийн болон хоногийн тун
17.5.2	Strength Unit		1..1	Төхт	Эмийн 1 удаагийн болон хоногийн тунг хэмжих нэгж
17.6	Duration of intakes		0..1	Coded text	Эмчилгээний хугацаа
17.7	Indication		0..1	Code	Эмийн хэрэглэх заалт, онош
17.8	Comments		0..1	Төхт	Анхааруулга, зөвлөмж
18	Зөвлөгөө				
18.1	Recommendation to patient		0..1	Төхт	Үйлчлүүлэгчид өгсөн зөвлөмж

19	Хавсаргасан тусгай файлууд		0..*	Хавсралт	
20	Тухайн эмнэлгийн цахим маягтыг хөтөлсөн эрх бүхий эмнэлгийн мэргэжилтэн				
20.1	Author Identifier		0..*	Ялган танигч	Эмч, эмнэлгийн мэргэжилтний ялган танигч
	18.1.1	Value	1..1	Техт	Эмч, эмнэлгийн мэргэжилтний ялган таних дугаар
	18.1.2	Assigner	1..1	Техт	Эмч, эмнэлгийн мэргэжилтний ялган таних дугаар олгосон байгууллага
20.2	Name		0..*		Эмч, эмнэлгийн мэргэжилтний нэр
	18.2.1	Family	1..1	Техт	Эцэг/эхийн нэр
	18.2.2	Given	1..1	Техт	Өөрийн нэр
20.3	Speciality		1..1	Техт	Тухайн тусламж үйлчилгээ үзүүлсэн эмч, эмнэлгийн мэргэжилтний мэргэшил
20.4	Location		1..1	Техт	Тусламж үйлчилгээ үзүүлсэн үзлэгийн кабинетийн байршил
20.5	Date and time complete		1..1	Техт	Тухайн маягтыг бөглөж дууссан он сар өдөр, цаг минут
21	Тухайн эрүүл мэндийн цахим маягтыг хөтлөх эрх бүхий эмч, эмнэлгийн мэргэжилтний харьяалагдах эрүүл мэндийн байгууллага				
21.1	Organization identifier		0..*	Ялган танигч	Эрүүл мэндийн байгууллагын ялган танигч
	19.1.1	Value	1..1	Техт	Эрүүл мэндийн байгууллагын ялган таних дугаар
	19.1.2	Assigner	1..1	Техт	Эрүүл мэндийн байгууллагын ялган таних дугаар олгосон байгууллага
19.2	Name		1..1	Техт	Эрүүл мэндийн байгууллагын нэр
19.3	Address		0..*	Хаяг	Эрүүл мэндийн байгууллагын хаяг

**ЭМНЭЛЭГТ ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛСЭН ТУХАЙ ТЭМДЭГЛЭЛИЙН
ӨГӨГДЛИЙН БҮТЭЦ, ТҮҮНД ТАВИГДАХ ТЕХНИКИЙН ШААРДЛАГА**

**Хүснэгт 1. Эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн тухай тэмдэглэлийн
өгөгдлийн бүтцийн нэгдсэн товчоон**

Баримт бичгийн бүрэлдхүүн хэсэг	Өгөгдлийн бүрэлдхүүн хэсэг	Opt	Өгөгдлийн төрөл	Өгөгдлийн элементийн давтагдах чанар шинж
1	Үйлчлүүлэгчийн талаарх мэдээлэл	Ш	Техт	Тийм
2	Тухайн эмнэлгийн цахим маягтыг хөтлөсөн эрх бүхий эмнэлгийн мэргэжилтэн буюу эмчлэгч, эмчийн талаарх мэдээлэл	Ш	Техт	Тийм
3	Эрүүл мэндийн байгууллага			
4	Лавлагаа тусламж авахаар илгээсэн тухай мэдээлэл	Ш	Техт	Тийм
5	Хэвтэн эмчлүүлсэн эписодын мэдээлэл	Ш	Техт	Тийм
6	Оношийн мэдээлэл	Ш	Техт	Тийм
7	Мэс засал, мэс ажилбарын талаарх мэдээлэл	Ш	Техт	Тийм
8	Дүрс оношилгооны үр дүнгийн мэдээлэл	Ш	Техт	Тийм
9	Лабораторийн шинжилгээний үр дүнгийн мэдээлэл	Ш	Техт	Тийм
10	Цус сэлбэлт	Ш	Техт	Тийм
11	Хэвтэх үеийн эмийн гаж урвалын талаарх мэдээлэл	Ш	Техт	Тийм
12	Эмнэлгээс гарах үеийн эмийн жор	Ш	Техт	Тийм
13	Эмнэлгээс гарах үеийн зөвлөгөө	Ш	Техт	Тийм
14	Эмнэлгээс гарах үед хавсаргасан эмнэлгийн баримт бичгүүд	Ш	Хавсралт	Тийм
Тэмдэглэгээ: Утга авах нөхцөл= Тухайн өгөгдлийн элементийг зайлшгүй байх эсэх эсвэл байхгүй байж болохыг эсэхийг тодорхойлно. Ш= Шаардлагатай С= Сонголтоор				

Хүснэгт 2. Эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн тухай тэмдэглэлийн өгөгдлийн бүтцийн элементүүд

		Бүрэлдэхүүн хэсэг	Card.	Өгөгдлийн төрөл	Тодорхойлолт
1	Үйлчлүүлэгчийн талаарх мэдээлэл				
1.1	Patient ID		0..*	Ялган танигч	Үйлчлүүлэгчийн ялган танигч
	1.1.1	Value	0..1	Техт	Үйлчлүүлэгчийн ялган таних дугаар
	1.1.2	Assigner	0..1	Техт	Үйлчлүүлэгчийн ялган таних дугаар олгосон байгууллага
1.2	Name		0..*	Техт	Үйлчлүүлэгчийн нэр
	1.3.1	Family	0..1	Техт	Эцэг/эхийн нэр
	1.3.2	Given	0..1	Техт	Өөрийн нэр
1.3	Birthdate		0..1	Огноо	Үйлчлүүлэгчийн төрсөн он сар өдөр
1.4	Gender		0..1	Кодолсон техт	Үйлчлүүлэгчийн хүйс
1.5	Address		0..*	Хаяг	Үйлчлүүлэгчийн хаягийн мэдээлэл
	1.5.1	Address line	0..1	Техт	Хаягийн мөр
	1.5.2	Aimag/city	0..1	Кодолсон техт	Аймаг, хот
	1.5.3	Soum/disrict	0..1	Кодолсон техт	Сум,дүүрэг
	1.5.4	Bag/khoroo	0..1	Кодолсон техт	Хороо,баг
1.6	Telecom		0..*	Contact point	Үйлчлүүлэгчийн цахим хаягийн мэдээлэл
	1.6.1	Type	0..1	Кодолсон техт	Цахим харилцаа холбооны хэрэгслийн төрөл
	1.6.2	Value	0..1	Техт	Цахим харилцаа холбооны дугаар, хаяг
	1.6.3	Use	0..1	Кодолсон техт	Цахим харилцаа холбооны хэрэглээ
2	Тухайн эмнэлгийн цахим маягтыг хөтлөсөн эрх бүхий эмнэлгийн мэргэжилтэн буюу эмчлэгч, эмч				
2.1	Author Identifier		0..*	Ялган танигч	Эмч, эмнэлгийн мэргэжилтний ялган танигч
	2.1.1	Value	0..1	Техт	Эмч, эмнэлгийн мэргэжилтний ялган таних дугаар
	2.1.2	Assigner	0..1	Техт	Эмч, эмнэлгийн мэргэжилтний ялган таних дугаар олгосон байгууллага
2.2	Name				Эмч, эмнэлгийн мэргэжилтний нэр
	2.2.1	Family	0..1	Техт	Эцэг/эхийн нэр
	2.2.2	Given	0..1	Техт	Өөрийн нэр
3	Тухайн эрүүл мэндийн цахим маягтыг хөтлөх эрх бүхий эмч, эмнэлгийн мэргэжилтний харьяалагдах эрүүл мэндийн байгууллага				

3.1	Organization identifier		0..*	Ялган танигч	Эрүүл мэндийн байгууллагын ялган танигч
	3.1.1	Value	0..1	Техт	Эрүүл мэндийн байгууллагын ялган таних дугаар
	3.1.2	Assigner	0..1	Техт	Эрүүл мэндийн байгууллагын ялган таних дугаар олгосон байгууллага
3.2	Name		0..1	Техт	Эрүүл мэндийн байгууллагын нэр
3.3	Address		0..*	Хаяг	Эрүүл мэндийн байгууллагын хаяг
	3.3.1	Address line	0..1	Техт	Хаягийн мөр
	3.3.2	Aimag/city	0..1	Кодолсон текст	Аймаг, хот
	3.3.3	Soum/disrict	0..1	Кодолсон текст	Сум,дүүрэг
	3.3.4	Bag/khoroo	0..1	Кодолсон текст	Хороо,баг
4	Лавлагаа шатны тусламж үйлчилгээ авахаар илгээсэн эрх бүхий эмч, эмнэлгийн мэргэжилтэн				
4.1	Referrer ID		0..1	Ялган танигч	Эмч, эмнэлгийн мэргэжилтний ялган танигч
	5.1.1	Value	0..1	Техт	Эмч, эмнэлгийн мэргэжилтний ялган таних дугаар
	5.1.2	Assigner	0..1	Техт	Эмч, эмнэлгийн мэргэжилтний ялган таних дугаар олгосон байгууллага
4.2	Name		0..1	Хүний нэр	Эмч, эмнэлгийн мэргэжилтний нэр
	5.2.1	Family	0..1	Техт	Эцэг/эхийн нэр
	5.2.2	Given	0..1	Техт	Өөрийн нэр
4.3	Role of Referrer		0..1	Техт	Илгээсэн эмч 1-Өрхийн эмч, 2-амбулаторын нарийн мэргэжлийн эмч, 3-эмчлэгч эмч
4.4	Health organization		0..1	Техт	Лавлагаа шатны тусламж үйлчилгээ авахаар илгээсэн эрх бүхий эмч, эмнэлгийн мэргэжилтэн харьяалагдах эрүүл мэндийн байгууллага
5	Эмнэлэгт хэвтэх/гарах үеийн эписодын мэдээлэл				
5.1	Type		1..1	Кодолсон текст	1-Төлөвлөгөөт 2- Яаралтай
5.2	Start date		1..1	Он сар өдөр	Эмнэлэгт хэвтсэн он сар өдөр
5.3	End date		1..1	Он сар өдөр	Эмнэлгээс гарсан он сар өдөр
5.4	Hospital stay days		1..1	Техт	Эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн хоног
7.5	Outcome		1..1	Техт	Эмнэлгээс гарах үеийн өвчтний биеийн байдал
7.5.1	Code		1..1	Техт	Эмнэлгээс гарах үеийн үр дүнгийн ангилал
	7.5.1.1	ID of coding list	1..1	Техт	Эмнэлгээс гарах үеийн үр дүнгийн ангилал
	7.5.1.2	Code from Coding list	1..1	Техт	1-эдгэрсэн,2- сайжирсан,3- хэвэндээ, 4- дордсон,5- нас барсан

	7.5.1.3	`Label of code of code list	1..1	Төхт	Сонгогдсон кодоо харгалзах үр дүн
7.6	Discharge separation		1..1	Төхт	Эмнэлэгээс гаргасан хэлбэр
7.6.1	Code		1..1	Төхт	Эмнэлгээс гаргасан хэлбэрийн ангилал
	7.6.1.1	ID of coding list	1..1	Төхт	Эмнэлгээс гарсан хэлбэрийн ангилал
	7.6.1.2	Code from Coding list	1..1	Төхт	1- Гарсан, 2- өөр эмнэлэгт шилжсэн,3- нас барсан
	7.6.1.3	Label of code of code list	1..1	Төхт	Сонгогдсон кодоо харгалзах үр дүн
8	Diagnosis			Оношийн талаарх мэдээлэл	
